



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.11.25 №45, 46 (10722, 10723)

Үнэ 500 төгрөг

— Дугаар эрхэлсэн ахмад М.МӨНХЗОРИГ

МЭНДЧИЛГЭЭ

Батлан хамгаалахын эрдэмтэн, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан Та бүхэнд Монгол Улсын шинжлэх ухааны ажилтны өдрийн баярын мэндийг дэвшүүлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Манай улс шинжлэх ухаан, технологийн энэ эрин үед шинжлэх ухааны судалгааны ажлыг эрчимжүүлэх, орчин үеийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, инновацыг хөгжүүлэхэд анхаарч "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод "Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацийн тогтолцоог хөгжүүлнэ" гэсэн зорилтыг дэвшүүлж, энэхүү зорилтын хүрээнд цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, батлан хамгаалах эрх ашигт нийцсэн технологийн инкубатор, туршилтын үйлдвэрийг байгуулж, инновацыг нэвтрүүлэх замаар цэргийн зориулалттай зарим бүтээгдэхүүнийг зохион бүтээж, дотооддоо үйлдвэрлэнэ хэмээн батлан хамгаалахын судалгаа, шинжилгээний алсын харааг тодорхойлоод байна.

Засгийн газрын 2020-2024

оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ" гэсэн зорилтыг дэвшүүлэн цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын агуулгыг олон улсын жишигт хүргэхийг зорьж тодорхой ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тухайлбал, салбарынхаа эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнг бэхжүүлэх, цэргийн шинжлэх ухааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулах шинэ бүтээл, шинэлэг-оноовчтой санал, санаачилгыг дэмжиж, инновацыг нэвтрүүлэхэд анхаарч ажиллах болно.

Манай цэргийн эрдэмтэн, судлаачид цэргийн шинжлэх ухааны суурь болон хэрэглээний судалгаа боловсруулалт, туршилт, хөгжүүлэлтийн ажлыг үр дүнтэй явуулж ирсэн билээ. Сүүлийн жилүүдэд залуу инженер офицерууд маань Зэвсэгт



хүчний инновацыг хөгжүүлэх чиглэлээр санаачилга гарган зэвсэглэл, цэргийн техникийг дотооддоо үйлдвэрлэх, турших ажлыг эхлүүлээд байна. Залуу судлаачдын бүтээлч сэтгэлгээ, бодит үр дүнг бодлогын түвшинд дэмжиж, улам боловсронгуй болгоход яамны зүгээс анхаарч ажиллах болно.

Монгол Улсын төрөөс баримталж

байгаа шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх зорилго, зорилтуудын хүрээнд цэргийн эрдэм судлалыг хөгжүүлэх, Зэвсэгт хүчинд технологийн дэвшил, инновацыг нэвтрүүлэх, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлох томоохон зорилтууд цэргийн эрдэмтэн, судлаач Та бүхний өмнө хүлээгдэж байна.

Улс орныг хөгжүүлэх, батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх бодлого, зорилтыг хангах, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэн бэхжүүлэхэд цэргийн эрдэмтэн, судлаач Та бүхний идэвхтэй, бүтээлч санал, санаачилга, хичээл зүтгэл чухал болохыг онцлон тэмдэглэе.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн гүйцэтгэхэд оюун санаа, сэтгэл зүтгэлээ зориулж буй шинжлэх ухааны ажилтан Та бүхэндээ баярын мэндийг дахин дэвшүүлж, Монгол Улсын шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд тань улам их амжилт хүсье.

Эрхэм баян эрдэм ухаан эгнэгт арвижин бадрах болтугай.

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР

Г.Сайханбаяр: ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД НЯГТ УЯЛДААТАЙ АЖИЛЛАХ ЁСТОЙ

Монгол Улсын хэмжээнд "Ковид-19" цар тахлын хоёрдогч давлагаа эрчимтэйгээр тархаж буй энэ цаг үед Батлан хамгаалах яамны газрын дарга нар тус яамны харьяа байгууллагуудын удирдлагуудтай цахим хурлыг өнгөрөгч долоо хоногийн Баасан гарагт зохион байгуулан үүрэг, чиглэл өглөө.

Харьяа байгууллагууд Бүх нийтийн хэлбэр байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн яамнаас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу халдвараас хамгаалах журмыг баримталж, хариуцлагатай жижүүр, эргүүлийг томилон ажиллуулж байна. Цэргийн төв эмнэлэгт 94 иргэн ажиглалтад тусгаарлагдсан бөгөөд одоохондоо тэдгээрийн биеийн байдал хэвийн байгаа аж. Мөн 65 эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан байнгын байрлалд үүрэг гүйцэтгэж байгааг мэдэгдлээ. Харин "Багабаян-Энхийн төлөө цогцолбор


төв"-д Өмнөд Судан Улсад энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгээд эх орондоо ирсэн цэргийн алба хаагчдыг тусгаарлаж байгаа бөгөөд Улсын онцгой комиссоос үүрэг, чиглэл авч ажиллаж байна. Харин Батлан хамгаалах яамны бусад харьяа байгууллагууд 12-оос доош насны хүүхэдтэй эцэг, эхчүүд болон онц шаардлагагүй гэж үзсэн ажилтан алба хаагчдыг гэрээсээ ажиллах нөхцөл, боломжоор хангаж байгаа гэдгийг танилцууллаа.

Хурлын төгсгөлд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар Сэлэнгэ аймагт томилогдон ажиллаж буй Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяраас харьяа байгууллагуудын удирдлагуудад хандан цар тахлын халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй байдлыг хангах чиглэлээр үүрэг,

чиглэл өгснийг нь уламжилсан юм. Тэрээр хэлэхдээ "Цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб хэрхэн ажиллах талаар сайд чиглэл өгсөн. Энэ хүрээнд өнөөдрийн цахим хурлыг зохион байгуулж байна. Бид бүхэн цар тахалтай тэмцээд 10 сарыг үдсэн. Харин энэ сараас эхлэн Монгол Улс дотооддоо халдварыг алдлаа. Энэ үед цэргийн алба хаагчид нийтээрээ нягт уялдаа холбоотой ажиллах ёстой. Энэхүү цар тахлын дэгдэлт 14 хоногийн хугацаанд намжихгүй бол онц байдалд шилжих магадлалтай. Улс орны хэмжээнд онц байдалд шилжихэд Зэвсэгт хүчин дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Зэвсэгт хүчний Жанжин штабаас Шуурхай удирдлагын бүлгийг байгуулан онц байдалд шилжих нөхцөлд ямар арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар танилцуулсан. Тиймээс харьяа байгууллагууд дор бүрдээ хариуцлагыг

өндөржүүлэх шаардлагатай байна. Батлан хамгаалахын сайдын зөвлөснөөр Гамшгийн тухай хуулийг сайтар судлах, байгууллага тус бүр эрсдэлийн үнэлгээ, нэгдсэн судалгааг гаргах, цэргийн алба хаагч өөрөө болон ар гэрийн гишүүн нь тусгаарлагдсан бол тухайн алба хаагчийг ажиллуулахгүй байх, сэжигтэй тохиолдол илэрсэн үед хэрхэн тусгаарлах талаар анхаарах, халдвараас хамгаалах нөөцийг бүрдүүлэх, санхүүгийн сахилга батыг анхаарах, хурал, шуурхай зөвлөгөөнийг цахимаар хийх, Засгийн газар, Улсын Онцгой комиссоос гарсан эрх зүйн баримт бичгүүдийг сайтар судлах, соён гэгээрүүлэх, сурталчилгааны ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлэх, жижүүр, эргүүлийн хариуцлагыг нэмэгдүүлэх зэргийг үүрэг болголоо. Үүнд Батлан хамгаалах яамны харьяа байгууллагууд хяналт тавин ажиллах учиртай" гэв.

ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЬЕ!



- ✓ Маскаа зүү
- ✓ Гараа угаа
- ✓ Дархлаагаа дэмж
- ✓ Бусдыг хүндэл
- ✓ Өөрийгөө хамгаал

Л.Ганчимэг: НЭГТГЭЛ, АНГИУДАД ТҮР ТУСГААРЛАХ БАЙРЫГ БАЙГУУЛЛАА

ЗХЖШ-ын Ар талын газрын Эрүүл мэндийн хангалтын хэлтсийн дарга, хурандаа Л.ГАНЧИМЭГЭЭС цаг үеийн асуудлаар тодруулга авлаа.

Улсын Онцгой комиссоос Бүх нийтийн бэлэн байдал зарласан энэ үед танай хэлтсээс ямар ажил, арга хэмжээг хэрэгжүүлж байна вэ?

-Зэвсэгт хүчний Жанжин штабын Шуурхай удирдлагын бүлэгт Эрүүл мэндийн хангалтын хэлтсийн дарга оролцож мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна. Бид Улсын Онцгой комисс болон бусад мэргэжлийн байгууллагуудаас өгсөн тушаал, шийдвэрүүдийг үндэслэн Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ оны нэгдүгээр сард батлан хэрэгжүүлсэн ба 4, 7 дугаар сард нэмэлт төлөвлөгөөг боловсруулан ажилласан.

Мөн Улсын Онцгой комиссоос ирүүлсэн чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад албан даалгавар хүргүүлэн хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Бүх нэгтгэл, ангитай байнгын холбоотой ажиллан өдөр бүр коронавирусийн халдварын үеийн үйл ажиллагааны мэдээг авч тухай бүрд нь тодотгож байна.

Зэвсэгт хүчний ангиудад

түр тусгаарлах байруудыг байгуулсан гэсэн. Энэ талаар мэдээлэл өгнө үү?

-Зэвсэгт хүчний нэгтгэл,



анги, салбаруудад сэжигтэй тохиолдол илэрсэн үед тухайн хүнийг цаг алдалгүй шууд тусгаарлах үүднээс бүх анги, салбаруудад түр тусгаарлах байрыг байгуулаад байна. Түр тусгаарлах байруудыг 50 гаруй сая төгрөгийн худалдан авалтаар ариутгал, халдваргүйтгэлийн иж бүрдэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгалын багаж, табель хэрэгсэл зэргээр хангасан. Ингэснээр ялангуяа хугацаат цэргийн алба хаагчидтай ангиудын цар тахлын үед ажиллах бэлэн байдал нь дээшилж, вирусийн халдвар тархах эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж байгаа юм.

Мөн Зэвсэгт хүчний эрүүл мэндийн хангалтын байдал, боломж, бэлэн байдлын хангалтад тодотгол хийж, энэхүү халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор анги, салбаруудын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, дадлагажуулсан.

Түүнчлэн, Зэвсэгт хүчний эрүүл мэндийн эрсдлийн сангаас коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд нийт 13 сая төгрөгийн ариутгал, халдваргүйтгэлийн бодисын худалдан авалтыг хийж, нэгтгэл, анги, салбаруудад нөхөн хангалт хийгээд байна. Түүгээр ч зогсохгүй хугацаат цэргийн алба хаагчдыг амны хаалтаар хангах зорилгоор нэгтгэл, анги, салбаруудад 24900 метр "самбай"-ны хангалтыг хоёр удаа хийлээ. Цаашдаа хугацаат цэргийн алба хаагчдыг нэг удаагийн зориулалтын амны хаалтаар хангах тоцоог гаргаж байна.

НЭГТГЭЛ, АНГИУДАЙ ЦАХИМААР ХОЛБОГДОВ



Монгол Улсын хэмжээнд цар тахлаас үүдэлтэй Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа С.Ганбямба, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр, Зэвсэгт хүчний Удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг нар Зэвсэгт хүчний бүх нэгтгэл, ангийн удирдлагуудтай цахимаар холбогдон үүрэг, чиглэл өглөө.

Энэхүү цахим хурлаар Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад цар тахлаас сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, халдвар хамгааллын журмыг хэрхэн мөрдөж байгааг танилцуулахын сацуу цэргийн гэрээт болон хугацаат алба хаагчдын аюулгүй байдлыг хамгаалахад анхаарч ажиллаж байгааг мэдэгдлээ.

Нэгтгэл, ангиудын захирагч нар танилцуулга хийсний дараагаар Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар "Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаас өгсөн үүрэг, чиглэлийг та бүхэнд танилцуулья. Нэгдүгээрт, хугацаат цэргийн алба хаагчидтай анги, нэгтгэлүүд онцгой дэглэм тогтоох шаардлагатай. Хоёрдугаарт, Улсын Онцгой комиссоос өгч буй заавар, зөвлөмжийн дагуу алба хаагчид хоорондоо хоёр метрээс дотогш зайд харьцахгүй байх, гуравдугаарт, тухайн нэгтгэл, ангиудад халдвараас урьдчилан

сэргийлэх, ариутгалын ажлыг маш сайн зохион байгуулах, дөрөвдүгээрт, сахилга, зохион байгуулалт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тал дээр анхаарах, тавдугаарт, цэргийн гал тогоонд ажиллаж буй ажилтан алба хаагчдыг урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулах, зургаадугаарт, хугацаат цэргийн алба хаагчдыг гаднын хүнтэй уулзуулахгүй байх, долоодугаарт, Засгийн газрын тогтоолуудтай сайтар танилцах үүргийг өгсөн юм. Мөн Онц байдалд шилжих нөхцөлд ямар арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар тандалт, судалгаа хийхийг нэгтгэл, ангиудын удирдлагууд зохион байгуулж ажиллах ёстой" гэв.

Үүний дараагаар Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзоригийн өгсөн үүрэг, чиглэлийг Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг уламжилсан юм. Тэрээр "Цар тахал эрчимтэй тархаж буй энэ цаг үед Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад аль болох цөөн тооны алба хаагчдыг ажиллуулах ёстой. Мөн ариутгал, цэвэрлэгээг тогтмолжуулж, хариуцлагатай эргүүл, харуул, хоногийн манаанд томилогдсон бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлтэд онцгой анхаарч ажиллахын зэрэгцээ хүйтний эрч нэмэгдэж байгаатай холбогдуулан нэгдсэн үйл ажиллагааг хязгаарлах, аарц, чацаргана зэрэг нэмэлт хүнсний бүтээгдэхүүнээр хангаж ажиллах үүргийг өгсөн. Цаашид цахим хурлыг тогтмол хийх учир бэлэн байдалд анхаарч ажиллах шаардлагатай"-г онцоллоо.

ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГЛӨӨ

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, ажлын албаны холбогдох мэргэжилтнүүд, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа С.Ганбямба болон тус газрын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн дарга, хурандаа С.Ванчинхүү нарын бүрэлдэхүүн "Ковид-19" цар тахал голомтлон гарч буй Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Сэлэнгэ аймгуудын болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга нартай цахим уулзалтыг энэ долоо хоногийн Даваа гарагт зохион байгуулж үүрэг, чиглэл өглөө.

Цахим уулзалтаар Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабууд тухайн орон нутагт үүсээд буй цагийн байдал, нийт халдвар авсан иргэдийн тоог багцлан хүргэхийн сацуу тусгаарлалтад байгаа сэжигтэй тохиолдлуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулсан юм. Мөн цар тахлын болзошгүй аюулт нөхцөл байдлаас сэргийлэх зорилгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж үүднээс хүнс, түлшний нөөц бүрдүүлэлтийн ажил болон хугацаат цэргийн алба хаагчдын Цэргийн тангараг өргөх ёслол амжилттай болж өндөрлөсөн талаар уламжиллаа.

Уулзалтын төгсгөлд хурандаа Ж.Болдбаатар "Монгол Улсад цар тахал улам эрчээ авч байна. Нөхцөл байдал хүндэрч болзошгүй байгаатай холбогдуулан Батлан хамгаалахын сайд таван чиглэлээр үүргийг өглөө.



Нэгдүгээрт, Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий бусад байгууллагуудтай нягт уялдаатай ажиллах, хоёрдугаарт, Гамшигаас хамгаалах хуульд зааснаар, Онц байдал зарлах шийдвэр гарсан тохиолдолд Зэвсэгт хүчний анги, салбаруудыг тусгайлан чиг үүрэг бүхий бусад байгууллагуудтай холбох ажлыг зохион байгуулах, гуравдугаарт, Онц байдал зарласан нөхцөлд үүрэг гүйцэтгэх томилоог тодотгох, дөрөвдүгээрт, гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг үндсэн үүргийнх нь дагуу дайчлах, тавдугаарт, Бүх нийтийн бэлэн байдлын зэргийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга, хэмжээ, үүссэн нөхцөл байдлын талаар цаг алдалгүй, түргэн, шуурхай мэдээлж ажиллахад анхаарах үүрэг өгсөн" гэв.

Үүний дараагаар Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа С.Ганбямба "Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан цар тахал голомтлон гарч байгаа аймгуудын ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нартай холбогдон ажиллаж байгаа. Тодорхой эрх зүйн болон зохион байгуулалтын зөвлөгөө, дэмжлэгийг үзүүлж байна. Тэдгээрийг зарим Цэргийн штабууд сайн хэрэгжүүлэн ажиллаж байгаагийн нэг нь Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб юм. Гамшигт нөхцөл байдлын үед Цэргийн штабууд ямар үүрэг, чиглэлтэй оролцох вэ гэдэг талаарх, хуулийг сайн судлах хэрэгтэй. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн дагуу Цэргийн штабууд чухал үүргийг хүлээдэг. Онц байдал үүссэн үед хуулийн дагуу зохион байгуулалт өндөртэй байж чадвал тухайн орон нутгийн Засаг даргын Тамгын газар болон иргэдэд орон нутгийн хамгаалалт нь өндөр ач холбогдолтой болохыг нь мэдэрүүлж чадна" гэв.

НЭГЭН ЗУУНЫ ОЙТОЙ ДАВХЦАЖ НЭГЭН ЖИЛИЙГ ХАМТДАА ҮДЭХ ДАЙЧИД

Монгол Улсад цар тахлын хоёр дахь давлагаа дэгдэж, Улсын Онцгой комиссоос Бүх нийтийн бэлэн байдал зарласан

сургалтад хамрагдан ийнхүү эх орондоо үнэнчийн баталгаа болсон Цэргийн тангараг өргөж байгаа юм. Коронавирусийн



энэ үед Зэвсэгт хүчинд 2020 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчид Цэргийн тангараг өргөлөө. Уг ажиллагааг Улсын Онцгой комиссын заавар, зөвлөмжийн дагуу Зэвсэгт хүчний ангиуд ариутгал, халдваргүйтгэл, аюулгүй байдлыг дээд зэргээр ханган зохион байгуулсан гэдгийг зайлшгүй дурдах нь зүйтэй.

Бид Цэргийн гавьяаны улаан тугийнондонд Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн дайчдын Цэргийн тангараг өргөх ёслолыг онцолж очлоо. Ирэх жил тус анги 100 жилийнхээ ойтой золгох Зэвсэгт хүчний ууган ангиудын нэг юм. 2020 оны II ээлжээр тус ангид 60 гаруй хугацаат цэргийн алба хаагч татагдан ирсэн бөгөөд тэд цэргийн анхан шатны

цар тахлын улмаас энэ үеэр дайчдын гэр бүлийнхнийг тус ангид ирэхийг хориглосон байлаа. Дайчид тангараг өргөсний дараа жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолтыг сонирхуулж, ангийн удирдлагадаа сургалтын явцад юу сурснаа үзүүлээд амжсан. Энэ үеэр тус ангийн захирагч, хурандаа Ц.Батсайхан дайчдад хандан хэлсэн үгэндээ "Цэргийн албанд татагдсан залуус маань өчигдөрхөн аав, ээжийн хүүхдүүд байсан бол өнөөдрөөс Цэргийн тангараг өргөж, эх орны хүү боллоо. Та бүхний алба хааж байгаа анги бол жанжин Д.Сүхбаатарын санаачилгаар байгуулагдсан 99 жилийн түүхтэй анги юм. Ангийн удирдлага, бие бүрэлдэхүүн та бүхнийг албаныхаа нэр хүндийг өндөрт өргөж, сургалт

бэлтгэл, сахилга бат, урлаг, спортын амжилтаараа манлайлна гэдэгт итгэж байна" гэсэн юм.

Мөн байлдагч Д.Мэгүжин дайчдаа төлөөлөн хэлсэн үгэндээ "Өнөөдөр бид Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн эх орондоо үнэнчийн баталгаа болсон Цэргийн тангараг өргөж байна. Өнөөдрийг хүртэл цэргийн анхан шатны мэдлэг, боловсролыг олгохын төлөө ахуй амьдралаа умартан бидний төлөө зүтгэсэн офицер, ахлагч нартаа мөр зэрэгцэн тангараг өргөсөн дайчдынхаа өмнөөс талархаж байгаагаа илэрхийлье" гэв. Дараа нь байлдагч Ж.Далайжамц "Би Хэнтий аймгаас хугацаат цэргийн албанд татагдсан. Арван настайгаасаа лам болж хийдэд шавилан сууж, чанд сахилгад суралцсан надад цэргийн албаны дүрэм, журам нь их нийцэж байна. Энэтхэг улсад бурхны ном судалж ирээд удаагүй бийхдээ цэргийн албанд явах шийдвэрээ гаргасан. Эх орон, тусгаар тогтнолын үнэ цэнийг мэдэрч, "Их хүрээ" хийдийнхээ залуу лам нар болон үе тэнгийнхэндээ үлгэр дуурайл үзүүлэх зорилгоор цэргийн алба хаая гэж бодсон" гэв.

Ирэх жил нэгэн зууныхаа ойтой золгох гэж байгаа энэ мөчид тус ангид татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчид сургалт, бэлтгэл, ур чадвараараа манлайлан Зэвсэгт хүчинд ангийнхаа нэрийг дуурсгаж, их ойдоо бэлэг барихаар хичээнгүйлэн суралцаж байна.

Ахмад М.МӨНХЗОРИГ

Хилийн чанадаас мэдээлж байна

ҮНДСЭН ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ ЭХЛЭЭД БАЙНА

БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын мандаттай "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн цэргийн баг 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс 10 дугаар сарын 3-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлийг өндөр ачаалалтайгаар зохион байгуулж, цэргийн алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүллээ. Ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл нь дэлхий нийтийг хамарсан цар тахлаас шалтгаалан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хорио цээрийн дэглэм тогтоосон нөхцөлд зохион байгуулагдсанаараа онцлогтой юм. Цэргийн багийн бие бүрэлдэхүүн 2020 оны 10 дугаар сарын 5-31-ний өдрүүдэд дөрвөн удаагийн тусгай үүргийн нислэгээр ажиллагааны газар орныг зорьсон билээ. Тодруулбал, эхний хоёр ээлжээр БНӨСУ-ыг зорьсон бүрэлдэхүүн НҮБ-ын заавар, зөвлөмжийн дагуу 10 дугаар сарын 6-25-ны өдрүүдэд Жуба хотод 14 хоногийн тусгаарлалт, ажиглалтын хугацааг өнгөрөөж,

10 дугаар сарын 26-ны өдрөөс Бенгью хот дахь дотоодын дүрвэгсдийн хуранд ажиллагааны үндсэн үүргээ гүйцэтгэж эхлээд байна.

Сүүлийн нислэгээр буюу 10 дугаар сарын 29, 31-ний өдрүүдэд ажиллагааны газар орныг зорьсон бүрэлдэхүүн тус улсын Жуба хотод мөн 14 хоногийн тусгаарлалт, ажиглалтад байна.

БНӨСУ-ын ерөнхий цагийн байдал тогтвортой байгаа боловч нутгийн ихэнх хэсэг малын хулгай, дээрэм болон түүнээс улбаатай өс хонзонгийн сэдэлтэй аллага, НҮБ-ын болон Олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудын байр, өмч хөрөнгө рүү халдах, ажилтнуудын амь нас, эрүүл мэндэд заналхийлэх явдал тасрахгүй байна.

Сүүлийн мэдээгээр, Өмнөд Судан улсад "Ковид-19" вирусийн бэлгэдсэн тохиолдол 2970 бүртгэгдсэнээс 2673 хүн эдгэрч, уг халдварт өвчний улмаас 69 хүн нас баржээ.

Хурандаа Д.ЭНХБААТАР

Хурандаа Г.Золзаяа: УРАН БҮТЭЭЛҮҮДЭЭ ИЛҮҮ ЧАНАРЖУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА

Энэ жил Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ой тохиосон. Түүхэн ойн хүрээнд Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгынхан олон бүтээлч ажлыг санаачлан хэрэгжүүлжээ. Ирэх жилүүдэд ч уран бүтээлийн өв санг баяжуулах, чуулгынхаа үйл ажиллагааг төгөлдөржүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлж байгаа талаар ЦДБЭЧ-ын дарга, Соёлын төв өргөөний Ерөнхий менежер, хурандаа Г.ЗОЛЗАЯАТАЙ ярилцлаа.

Цаг хугацааны хувьд оны сүүл үе дөхөж байна. Энэ жил танай хамт олон ямар ажлуудыг санаачлан хийж гүйцэтгэсэн бэ?

-ЦДБЭЧ-ын бие бүрэлдэхүүн энэ жил тодорхой зорилго, зорилтуудыг тавьж, тэр хүрээнд ажлаа төлөвлөн шатлан хэрэгжүүлж байна. Гол нь 2020 онд Чөлөөлөх дайны ялалтын түүхэн ой тохиосон. Яагаад энэхүү ойг онцлон хэлж байгаа вэ гэвэл, Чөлөөлөх дайнд Монгол Улсаас урлагийн ганцхан байгууллага бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, дайчидтайгаа мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэсэн нь тухайн үеийн Цэргийн Дуу, Танцны Ансамбль буюу өнөөгийн ЦДБЭЧ юм. Тус байгууллага нь тухайн үедээ 60 хүний бүрэлдэхүүнтэйгээр нутгийн ард олон болон цэрэг, дайчдаа 22 удаагийн тоглолт, уран бүтээлээ толилуулж, нэг гартаа бугаа, нөгөө гартаа хөгжмөө барин дайны фронт руу цуваа татуулж явсан түүхтэй. Тиймээс энэ жил "Дайнд оролцсон Дайчин чуулга" нэртэй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Нэн тэргүүнд уран бүтээлчдийнхээ ур чадварыг нэмэгдүүлэх, урын сангаа баяжуулах, шинэ, шилдэг бүтээлүүдийг төрүүлэх зорилгыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд зарим алба хаагчдаа мэргэжлийн урлагийн байгууллагуудад бакалавр, магистрын зэрэг олгох болон гадаад хэлний сургалтуудад хамруулах нөхцөл, боломжийг нь бүрдүүлсэн. Дээрээс нь, уран бүтээлчдийнхээ дунд "Шинэ уран бүтээл, шилдэг уран бүтээлч шалгаруулах уралдаан"-ыг зохион байгуулсан. Тус уралдаан нь ЦДБЭЧ-ын урын санг баяжуулах, гоцлол уран бүтээлчдийг дэмжих, хамт олны бүтээлч санаачилгыг хөгжүүлэх үндсэн зорилготой. "Шинэ уран бүтээл, шилдэг уран бүтээлч шалгаруулах уралдаан"-д нийт 54 бүтээл оролцохоор бүртгүүлсэнээс 36 нь "Шинэ уран бүтээл"-ийн төрөлд, 23 нь "Шилдэг уран бүтээлч"-ийн төрөлд өрсөлдсөн. Төрөл тус бүрээс гурван уран бүтээл шилдгээр нь шалгарсан. Шагналт байрт шалгараагүй ч ЦДБЭЧ-ын урын санд заавал байх ёстой

бүтээлүүд ч төрөн гарсан. Тус чуулгын хамт олон Монгол цэргийн өдөр, Үндэсний их баяр, наадам зэрэг тэмдэглэлт өдрүүдээр томоохон тоглолтуудыг олон түмэнд хүргэдэг. Тиймээс урын сангаа баяжуулах нь ихээхэн ач холбогдолтой. Мөн хуучны сэтгэлд хоногшсон уран бүтээлүүдээ залуучуудаараа дамжуулан сэргээе гэсэн бодлыг тээж дээрх уралдааныг зохион байгуулсан.

Нөгөө талаар, бид бие бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг сайжруулах талаар анхаарч, зарим ажыг хийж гүйцэтгэлээ. Оны эхэнд чуулгынхаа бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлуулах асуудлыг БХЯ-нд хандаж шийдвэрлүүлсэнээр олон дэвшилтэт асуудлыг бодлогын хүрээнд бодит ажил болгосон. Бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хамт олноороо хэлэлцэж, чуулгын даргын тушаалаар баталгаажуулан, дагаж мөрдөж эхлээд байна. Энэхүү дотоод журамд урын сангийн шаардлага хангасан уран бүтээлийг худалдан авах, уралдаан, тэмцээнд амжилт гаргасан алба хаагчдыг урамшуулан дэмжих асуудлууд багтсан нь ач холбогдолтой юм.

Мөн оны эхнээс төрийн үйлчилгээний алба хаагчдад алба хаасан хугацааны нэмэгдлийг олгож эхэлснээр нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх нэг алхам болж чадсан. Бидний нэг зорилго бол эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд ажиллах, уран бүтээлээ туурвих асуудал байдаг. Энэ зорилтын хүрээнд бид бялдаржуулах танхимыг байгуулах, бие бүрэлдэхүүнээ эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах, рашаан, сувилалд алба хаагчдаа амраан сувилуулах зэрэг асуудлыг ч шат дараатайгаар шийдвэрлэж байна. Дээрээс нь, "Тохилог өрөө, тасалгаа, ажлын байр" уралдааныг зарлаж, үүгээрээ уран бүтээлчид маань ажлын байрандаа аюулгүй, тав тухтай ажиллах таатай орчноо бүрдүүлсэн. Мөн БХЯ-наас чуулгын гадна талын дулаан



болон цэвэр усны шугамыг бүрэн шинэчлэх төслийг шийдвэрлэж өгснөөр байгууллагын үйл ажиллагаа тогтвортой явагдахад бодит дэмжлэг болсон. Энэ асуудлыг шийдэж өгсөн Батлан хамгаалахын сайд болон сайдын зөвлөлийн гишүүдэд хамт олныхоо талархлыг уламжилъя.

Цар тахлын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн энэ цаг үед зарим телевиз, радиотой хамтран өөрсдийн урын сан дахь болон МҮОНРТ-ын сан хөмрөгт байдаг бүтээлүүдээ үзэгч, сонсогчдоо хүргэж байна. Мөн Аугаа их Эх орны дайны ялалтын баяраар цахим тоглолтыг зохион байгуулсан нь олон нийтэд хүрч чадлаа. Энэ жил цахимаар явагдсан Үндэсний их баяр, наадмын нээлт, хаалтын ёслол, хүндэтгэлийн тоглолтуудад манай нийт уран бүтээлчид оролцсон. Монгол Улсын Засгийн газраас санаачилсан, Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Соёлын цаг" аянд Батлан хамгаалах яам нэгдсэнтэй холбогдуулан Улаанбаатар хотын өсөндүүрэг, дөрвөн аймгийн өсөн суманд нийт 37 удаагийн тоглолтыг хийж, 13,800 хүнд урлагаар үйлчиллээ. Энэ арга хэмжээнд урлагийн долоон бригадыг томилон ажиллуулсан ба урлагийн бригад бүр өөр өөр хөтөлбөртэйгөө тоглолтоо толилуулсан. Саяхан тохиосон "Монгол бахархлын өдөр"-өөр бид Соёлын яамтай хамтран "Чингис хаан" рок дууриа "UBS" телевизээр нэвтрүүлсэн, цаашид

ч тоглолт, уран бүтээлээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэддээ хүргэх болно.

Цаг үеийн ямар ажлууд өрнөж байна вэ?

-Чөлөөлөх дайны түүхэн ойн жилтэй холбогдуулан бидний хийж, бүтээж буй өөр нэг ажил нь ЦДБЭЧ-ын Сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга, хошууч Р.Өнөржаргалын зохиол, Найрал дууны албаны дарга-Ерөнхий хормейстер, ахмад О.Эрдэнэцогийн хөгжим, МУГЖ Л.Ганчимэгийн найруулгаар бүтээж байгаа "Ялалт дархалсан намар" нэртэй түүхэн сэдэвт дуулалт жүжиг юм. Энэ бол тэртээ 1945 онд Цэргийн Дуу, Танцны Ансамблийн бүрэлдэхүүн цэргийн дээд удирдлагаас тушаал авч 2000 гаруй километр бартаат замыг туулан Өвөр Монгол, Зүүн хойд Хятадын нутгаар дайран, чөлөөлөгдсөн нутгийн иргэд болон цэрэг дайчдыг уран бүтээлүүдээрээ дамжуулан зоригжуулж, сэтгэл санааг нь өргөж байсан талаарх бодит түүхийг харуулсан бүтээл гэж ойлгож болно. Түүнчлэн "Хүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үүднээс иргэд, залуус, хойч үедээ эх орны үнэ цэнтэй иргэн байх, эх орноо хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх зорилгын дор "Аминаас ч үнэтэй эх орон" телевизийн нэвтрүүлгийг 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр үзэгч олондоо хүргэнэ.

Ирэх жилүүдэд ямар бүтээлч ажлыг хийхээр төлөвлөж байна вэ?

-Ирэх жил Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100, Батлан хамгаалах яамны 110 жилийн түүхэн ойнүүд тохионо. Энэхүү ойн хүрээнд тус чуулга иргэдэд тоглолт, уран бүтээлээ толилуулах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор ажлаа төлөвлөн төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн ажиллагаануудад мэргэжлийн урлагийн байгууллага, телевиз, радио болон "Харанга" хамтлагтай хамтран тоглолт хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Тус чуулгын 90 жилийн ой 2022 онд тохионо. Энэ ойг угтаж урын сангаа баяжуулах, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилтууд бидний өмнө бий.

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

Ч.Бумцэнд: САХИЛГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАМГИЙН ЧУХАЛ

Зэвсэгт хүчний гол цөмийг төрөл мэргэжлийн цэргийн алба хаагчид бүрдүүлдэг. Энэ ч үүднээс тэдний ажил, үүргийн онцлогийг бусдад таниулах үүрэг "Соёмбо" сонинд онгоддог юм. Анх их сургуулиа төгссөн цагаасаа эхлэн Батлан хамгаалах салбарт хөг, хөдөө гэлтгүй хоёргүй сэтгэлээр зүтгэж яваа алба хаагчдын нэг нь Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 321 дүгээр ротын захирагчийн орлогч, ахмад Ч.БУМЦЭНД юм.

Уншигчдад өөрийгөө танилцуулна уу?

-Би Хөвсгөл аймгийн уугуул, 1991 онд төрсөн. 2008 онд дунд сургуулиа төгсөөд элсэлтийн ерөнхий шалгалт өгч шуудхан л их сургуульд орох мөрөөдөлтэй байсан хэдий ч боломж хомс байв. Учир нь, тухайн үед ар гэрийн асуудлаас болоод ажил хийх шаардлагатай болсон хэрэг. Тиймээс барааны захад наймаа хийж эхэллээ. Сурагчийн ширээнээс ажил хийж эхэлсэн учир ямар мэргэжил надад зохих бол гэсэн бодол байнга эргэлдэнэ. Ингэж бодсоор жил орчмын хугацаа өнгөрлөө. Тухайн үед одоо л ямар нэгэн мэргэжил эзэмшихгүй бол болохгүй нь гэж зориглон ээж, аавдаа хэлтэл цэргийн сургуульд сурахыг зөвлөсөн юм. Надад ч гэсэн цэргийн хүн болох хүсэл, сонирхол байсан болохоор шалгалт өгч 2009 оны намар Батлан хамгаалахын их сургуулийн Радио электроник, техникийн инженерийн ангид элсэж байлаа. Багаасаа физик, математикийн хичээлд сонирхолтой байсан болохоор энэ мэргэжил надад хамгийн дөхөм байсан. Дээрээс нь бид мэдээ, мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа. Үүнийгээ дагаад улс орны Зэвсэгт хүчин ч бас энэхүү салбар руу хүч түрэн орж ирж байгаа гэсэн шалтгааныг үндэслэн үг мэргэжлийг сонгосон. Манай анги 40 хүүхэдтэй байснаас 10 нь л сонсогч болж чадсаны нэг нь, би. Бид 2013 онд төгссөн.

Сонсогч байх үеийн дурсамжаасаа хуваалцвал ...

-Хожим бодоход маш сайхан дурсамжтай цаг хугацаа байсан. Анх цэргийн дүрэмт хувцас өмсөхөөс эхлээд дэг журам, сахилга, зохион байгуулалт гэдэг хэр чухлыг нь ухаарсан. Нэг удирдлага, нэг команддаар нэгэн зэрэг хөдөлж, дүрэм, журмыг дээдэлж, түүнийгээ дагаад ч цэрэг хүний мөн чанарыг сайн ойлгосон. Бид өндөр зохион байгуулалттай байж л эх орноо батлан хамгаалж чадна гэдгийг бие, сэтгэлээрээ ойлгосон он жилүүд байлаа. Анх "каринтин"-д гарахад

шантрах зүйлс байгаагүй. Өөрөө чин сэтгэлээсээ хүсэж, мөрөөдөж байсан болохоор ядах юмгүй даваад л гарсан. Харин дараахан нь ногоо хураалтад бүтэн сарын хугацаатай явах л хүнд санагдаж билээ. Энэ үед биднийг сонсогч болсонтой зэрэгцээд манай сургууль бүтэц, орон тооны өөрчлөлт хийж, таван жилийн сургалтын хөтөлбөртэй байсан нь дөрөв болж өөрчлөгдсөн. Тиймээс бидэнд дээд оны ах нар гэж бараг байсангүй. Бидний дээд оныхон биднээс ч хожуу сонсогч болж билээ. Бид нар ах нь, та нар дүү нь гэх мэтээр битүүхэндээ хоорондоо өрсөлддөг байлаа.

Ажлын гараагаа хаанаас эхэлж байв?

-Сургуулиа төгсөөд Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн салбарт томилогдсон. Манай анги тухайн үед байгуулагдаад нэг жилийн нүүрийг үзэж буй шинэхэн анги байлаа. Энэ үед Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн 50 жилийн ойн хүрээнд маш их ажлыг хийж гүйцэтгэсэн цаг хугацаа байсан юм. Миний хувьд тус салбарын техник, тоног төхөөрөмжид засвар, үйлчилгээг хийхээс эхлээд нэлээдгүй ажилд гар бие оролцсон. Энэ маань ч надад их зүйлийг сургасан. Дээрээс нь, тухайн цаг хугацаанд хамт ажиллаж байсан чадварлаг ах, эгч нар, дарга, удирдлагууд маань их зүйлийг зааж, зөвлөсөн. Ерөнхийдөө их сургуульд үзсэн онолын мэдлэгээ бататгаж, улам л боловсорсон гэж хэлж болно. Одоо ч тэдний зааж, зөвлөсөн зүйлс үргэлж хэрэг болдог. Аливаа зүйлийг сурах хүсэл байгаад түүнийг нь зөвөөр чиглүүлэгч хэн нэгэн байхад л цааш хөгжих үндэс суурь болдог юм байна лээ. Ийнхүү тус салбарт нэг жил гаруй хугацаанд албан үүргээр гүйцэтгэлээ. Гэтэл 2014 оны намар Баянхонгор аймагт байрлах салбарт салааны захирагчаар томилогдох санал ирлээ. Би ч тухайн үед хөдөө, орон нутагт ажиллах сонирхолтой байсан бөгөөд шуудхан л зөвшөөрсөн. Тэнд мөн л жил гаруй хугацааг өнгөрөөсөн. Тэр хугацаанд орон нутагт байрлах

салбарын ажил, үүргийн онцлог ямар байдгийг мэдэж авсан. Дээрээс нь, говь нутагт жилийн дөрвөн улирал ямар байдгийг нь мэдэрч, хүн зоны харилцаа, нутгийн соёлд суралцсан гэх үү дээ. Дараа нь, Баян-Өлгий аймагт байрлах салбарт захирагчийн орлогчоор томилогдсон. Тэнд үүрэг гүйцэтгэх хугацаанд гэр бүлтэй болсон. Ийнхүү тус салбарт гурван жил орчим хугацааг өнгөрөөсний эцэст 2018 оноос хойш өнөөг хүртэл энэ салбартаа албан үүргээ гүйцэтгэж байна. Төрсөн нутагтаа аав, ээж, ах, дүүстэйгээ ойр ажиллаж, амьдарч байгаадаа сэтгэл хангалуун явдаг. Ерөнхийдөө сургуулиа төгссөнөөс

Тэгсэн хэдий ч бид хоёр анхнаасаа л бие биеэ гэсэн сэтгэлээр татагдсан учир эцэг, эхийн хэлсэн үгсийг чихнийхээ хажуугаар л өнгөрөөгөөд байсан. Цаг хугацаа өнгөрөх тусам л илүү төвөгтэй болоод байгаа юм шиг санагддаг байв. Нэг өдөр би зориг гарган хадмууд дээрээ өөрийн биеэр очиж уулзлаа. Өөрийнхөө учир байдлыг сайн тайлбарлаж, цаашид яаж амьдрах, охинд нь ямар их сэтгэлтэй талаар бүгдийг нь хэлчихсэн. Хадмууд маань гэр бүлийнхээ зарим ахмад настнуудтай зөвлөлдөж байж болье гэхэд нь энэ харилцаагаа үргэлжлүүлэх боломж байна гэдгийг мэдэрсэн. Манай гэр бүлийн зүгээс энэ харилцааг

байдаг юм шиг санагддаг. Учир нь салбар нь анги, байгууллагуудыг бодоход алба хаагчдын орон тоо, техник, тоног төхөөрөмж хомс. Хамгийн гол нь, тийм байх тусам алба хаагчид өөрсдийгөө хөгжүүлж, шинийг санаачлан өөрөөр сэтгэж, хамт олонч байдлыг үүсгэж чаддаг. Бүхий л зүйл нь бэлэн байсан бол алба хаагчид өөрсдийгөө дайчлан хөгжүүлэх боломж бага байх болов уу. Тиймээс салбарын алба хаагчдаа өндрөөр үнэлдэг.

Батлан хамгаалах салбарт алба хаадаг хүний хувьд эх орны үнэ цэн гэдгийг юу гэж ойлгодог вэ?

-Эх орон гэдэг бол би. Учир



хойш тасралтгүй салбаруудаар дамжин үүргээ гүйцэтгэж байна.

Гэр бүлийнхнийхээ талаар тодруулахгүй юу?

-Эхнэр маань казах бүсгүй. Бид Б.Ингүүмэл, Б.Эмүжин гэдэг хөөрхөн охидтой.

Казах, монгол хүмүүс хоорондоо гэр бүл болох нь маш цөөн гэж сонсож байсан. Таны эхнэр казах бүсгүй гэдэг нь тун сонирхол татаж байна ...

-Ёстой л нэг хувь тавилан юм даа гэж боддог. Анх сумын төвд зохион байгуулсан соёл, спортын өдөрлөг дээр Д.Галила гэдэг хөөрхөн казах охинтой танилцаж байсан. Дараа нь, бүр уулздаг боллоо. Тухайн үед манай хүний гэр бүлийн талаас нэлээдгүй дургүйцсэн. Казах хүн заавал өөрийн үндэстэнтэйгээ гэр бүл болох ёстой гэсэн үгс их сонссон.

хэдийнээ зөвшөөрчихсөн учир хэдэн сар хүлээсний эцэст ээж маань хадмын руу уулзахаар явлаа. Хоёр талын гэр бүл уулзалдсаны эцэст бүрэн зөвшөөрсөн дөө. Харин одоо бол хадмуудтайгаа их сайхан харилцаатай.

Хөдөө, орон нутагт байрлалтай тусгай салбарт үүрэг гүйцэтгэхийн онцлог тал нь юунд байдаг вэ?

-Тусгай салбар нь Монгол Улсын Зэвсэгт хүчний чухал нэгж юм. "Эхлээд хүн, тэгээд эр хүн, харин дараа нь цэргийн хүн бол" гэдэг үг бий. Миний хувьд яг л үүн шиг салбараар дамжиж цэргийн хэргийн нь ч тэр, амьдралын ч тэр мэдлэг, туршлага олж авч байна. Салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нарт аливаа зүйлд үнэн сэтгэлээсээ ханддаг, бүтээлчээр сэтгэдэг зэрэг чухал зан чанар илүү

нь бидний эх орон гэдэг зүйлийг монгол хүн бий болгож байгаа. Би монгол хүн. Тиймээс би өөрийн гэр бүлээ яаж авч явах, үр хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэхээс, эзэмшсэн мэргэжилдээ хэр зэрэг "эзэн суухаас" эх орон эхэлдэг гэж боддог. Дүгнээд хэлэхэд, эх орныг бие хүн л бий болгоно. Тэр тусмаа Батлан хамгаалах салбарт алба хаадаг хүний хувьд шударга байдлыг эрхэмлэх нь чухал. Амьдрал, ажил мэргэжилдээ шударга хандаж байж л үр хүүхэд, хойч үе маань зөв нийгэмд өсөн торних учиртай. Орчин үед эх орны үнэ цэн гэдэг ойлголт бага зэрэг алдагдсан гэж боддог. Эх оронч үзэл оршин байхын хэрвэл үнэ цэн нь бий болдог. Зэвсэгт хүчнийхээ хөгжилд бие, сэтгэлээ бүрэн зориулан албаа нэр төртэй хаах ёстой хэмээн бодож явдаг.

Дэд ахлагч Т.ИДЭР

БИДНИЙ НЭГ



АЖИЛ, АМЬДРАЛЫН ЗАМ НЬ СҮҮН МӨРТЭЙ ...

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний ариун жагсаалд хоёргүй сэтгэлээр амжилт дүүрэн зүтгэж ирсэн эгэлхэн агаад эрхэм гавьяатай хүмүүний амьдрал, ажил үйлсийн талаарх нийтлэлээ тэрлэж, уншигч танд толилуулсаар ирсэндээ туйлын ихээр бахархаж явдгаа нуух юун билээ. Харин энэ удаа жирийн нэгэн жолооч гэр бүлийн эгэл бор амьдрал дунд ирээдүйн сайн сайхны гэрэл гэгээ ямагт тодорч, энх амгалан, элбэг жаргалын үүд нь байнга нээлттэй байдгийг батлан чухамдаа эзэн хичээвээс заяа нь зөв байдгийн үлгэрлэлийг өөрийн биеэр мэдрүүлсээр буй бэлтгэл хурандаа Лувсандоржийн Чулуунбаатарыг онцлоо.

Түүний аав М.Лувсандорж нь Завхан аймгийн Алдархаан сумын Яруугийн хүрээнд төрж, өссөн бөгөөд жолооч мэргэжлийг эзэмшин эх орныхоо хөгжилд өөрийн гэсэн жинтэй хувь нэмрээ оруулсан өгөөмөр ачтан байжээ. Харин ээж Д.Бадамханд нь 11 хүүхдийг төрүүлж, өсгөсөн алдарт эх юм. Тийм л эгэл жирийн амьдралаас өөрийн олж авсан зөв хүмүүжил, төлөвшилийн үр дүнд аав, ээжийнхээ зөвлөгөө, амин сургаалыг нь дээдлэн цэргийн боловсрол эзэмшиж, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд хийсэн, бүтээсэн гавьяатай, хожмоо дурьсагдах алдартай, ариун зам, гэгээн мөртэй яваа эрхэм хурандаагаар бахархах сэтгэл өөрийн эрхгүй төрдөг юм. Учир нь 1980-аад оны сүүлийн жилүүдэд тухайн үеийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн ротын захирагч, улс төрийн орлогч болон курсийн дарга нар Ардын Армийн

даалгасан ажлаа “чанарын өндөр түвшин”-д гүйцэтгэснээр богино цагаар гудамжинд тоглох зөвшөөрөл авдаг байлаа. Тэр үед маатаг тоглох, уралдаж гүйх, уртад харайх, морь барилдаан, гудамжны сагс, өвөлдөө бол хоккей тоглох, цана, чаргаар гулгах гээд тоотой хэдхэн тоглоомтой байсан үе юм. Тэрээр 1969 онд манай улсын ууган сургуулийн нэг болсон 3 дугаар дунд сургуулийн нэгдүгээр ангид элсэн суралцсан ба түүний ангид сурлага, сахилгаар тэргүүний, урлаг, спортын сайчууд маш олон байсан нь анги удирдсан Дарьсүрэн багшийнх нь суралцданаа төлөө хэмээх чин эрмэлзэл, ажил хэрэгч, хөдөлмөрч үйл ажиллагааны үр дүнд гэж үнэлэх учиртай. Тэднийг 4 дүгээр ангид орох үеэс анги удирдсан багш нь “физик, математикийн” хэмээн алдаршсан Б.Доржсүрэн байжээ. Энэ л багш нь ангийнхаа суралцдыг эрдэм боловсролтой, сахилга баттай, зөв төлөвшилтэй болгох, хожмоо өөрийн амьдрал, ахуйгаа хэрхэн авч явахыг нь байнга зөвлөдөг эрхэм гавьяатны нэг байсан учраас тэд өдгөө ч багшийгаа хүндэлсээр, түүнтэй байнга уулзаж, баяр хөөр, баясал цэнгэл, бахархал дүүрэн хүүхэд насны дурсамжаа хүүрнэдэг нь бахдалтай аж. Энд тодруулахад, тэр бүхний бодит жишээ нь тус сургуулийн үе үеийн төгсөгчдөөс анги удирдсан эрхэм багш Б.Доржсүрэнгээ шинэ байртай болгох санаачилга гаргасан нь биеллээ олж, энэхүү үйл хэрэгт Л.Чулуунбаатар хурандаа маань ч жинтэй хувь нэмэр оруулснаараа бахархаж яваа.

Эрхэм хурандаагийн ангийнхан тэр бүр олноороо үлзалдаад

цэргийн сургуулийн хуваарь авъя гэтэл, ангийн багш Б.Доржсүрэн нь “Чулуунбаатар гадаадын сургуульд явбал, оюутан зодож, хэрэгт орно. Тэгээд сургуулиас хөөгдөж мэднэ шүү” хэмээн шоглож хэлсэн гэдэг. Учир нь тэр бээр боксоор хичээллэдэг бас тэрүүхэн хавьдаа “атаман” байсан болохоор багш нь тэгж өгөөдсөн хэрэг. Энэ үед тэрээр сурагчийнхаа хувийн хэрэг, боловсролын гэрчилгээгээ аваад Цэргийн ерөнхий дээд сургуулийг зорьсон бөгөөд тус сургуулийн хэд хэдэн ангид элсэлтийн шалгалт өгөх бололцоотой байсан ч нэгдүгээр группээр өрсөлдөн улс төрийн ангид суралцах эрхээ гардсан нь түүний хувьд мартагдашгүй нэгэн дурсамж байлаа. Ингэж л түүний сонсогч үеийн түүх эхэлсэн бөгөөд 1979 оны намар “карантин”-д гарч, цэрэг амьдралд хөл тавьсан юм.

Энэ тухайд тэр бээр “Бидний сонсогч үеийн эхний дурсамж нь өглөөний бослогоос үдшийн зугаалга, оройн тоо хүртэл нэгэн жигдийн амьдрал, нэгдсэн цагийн хуваарьт ажиллагаагаар үргэлжилсэн түүхтэй. Цэргийн анхан шатны болон ерөнхий бэлтгэлийн сургалт дуусаж, шалгалтаа ч амжилттай өгсөн бид Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоо гялалзуулсан Байлдааны тугийн дор цэргийн тангараг өргөж, “эх орны хүү” болсон юм даа. Энэ л үеэс цэргийн казармд дөрвөн жил хамтдаа амьдарч, цэргийн хэрэгт шамдан суралцаж билээ. Манай улс төрийн ротынхон сургуулийн хэмжээнд ямагт манлайлагч нь байж, аливаа уралдаан, тэмцээнд тогтмол эхний байруудад шалгарч, сурлагаараа бусад рот, курсийнхнийг тэргүүлж ирснийг үнэн түүх гэрчилдэг юм даа” хэмээн дурсан ярьсан.

Энэхүү улс төрийн ангийн хичээлийн хөтөлбөрт Ерөнхий цэрэг, холбоо, артиллери, авто, танкийн мэргэжлийн бүхий хичээлийг оруулдаг нь тухайн үед “Улс төрийн амжилтан бүр бүх мэргэжлийг тэгш эзэмшсэн, төгс офицер байх” зарчмыг мөрдлөг болгож ирсний тод жишээ юм.

Бидэнд мэргэжлийн хичээлүүдийг тухайн үед “Улаанхуарангийн 10 марксист” хэмээн хүндлэгдсэн Л.Дамбийням, С.Баатар, Б.Банзрагч, Ё.Моголцог, Ч.Лувсандорж, С.Даваадорж, Т.Хасгиа нарын тэргүүлэгч багш нар хичээл заадаг байсныг би бээр батлах бөлгөө. Энд тодруулбал, тухайн үеийн Нам, улс төрийн ажлын тэнхимийнхэн ихээхэн алдартай байсны дотор багш Ренчиннямын Амаржаргал, 1989 оны төгсөгч Ухнаагийн Хүрэлсүх нар Монгол Улсын Ерөнхий сайдын, мөн төгсөгч Гүрсэдийн Сайханбаяр Батлан хамгаалахын сайдын өндөр хариуцдагтай албыг хашиж, багш, хурандаа Б.Банзрагч, А.Гэлэжамц, Г.Мягмаржав, дэд хурандаа Б.Галиндэв нар гавьяат багш хэмээх эрхэм цолыг хүртсэн төдийгүй, нийт багш нар маань доктор, профессор хэмээх цолтон болсноор нь бид ямагт омогшдог юм.

Ийнхүү сонсогч насны дөрвөн жилийн хугацааг амжилт дүүрэн өнгөрүүлсэн тэдний курсийн төгсөгчдөөс Л.Чулуунбаатар, З.Баярмагнай, Г.Энхбаатар нар онц дүнтэйгээр сургуулиа төгсөж, хожмоо хурандаа хэмээх эрхэм цолын эзэн болсон нь бас л нэгийг өгүүлэх авай.

Тэрчлэн тэрээр гуравдугаар курсээсээ улс төрийн ротын жагсаалын даргаар томилогдон ахлах түрүүч цол хүртсэн бөгөөд ротод цэргийн албыг хэвшүүлэх, сонсогчдыг цагийн хуваарьт ажиллагаанд бүрэн хамруулах, өдөр тутмын үйл ажиллагааг дэг журамтай зохион байгуулах, гэмт хэрэг, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ротын бичиг хэрэг, аж ахуйг удирдах гээд олон ажлын ард төвөггүйхэн гарч байснаа ч илэн далангүй дэлгэж билээ.

ОФИЦЕР ҮЕИЙН ОНЦЛОХ ЖИЛҮҮД

1983 оны зун сургуулиа онц дүнтэй төгссөн, ахлах түрүүч

Л.Чулуунбаатар Батлан хамгаалах яамны сайд, хурандаа генерал Ж.Ёндонгоос диплом, энгэрийн тэмдэг, дэслэгчийн мөрдсөө гарджээ. Тэр жилийн шинэхэн төгсөгчид Ардын хувьсгалын 72 жилийн ойн цэргийн парадад офицерын шинэ хайрцгийг бүрдүүлэн алхсан бөгөөд Батлан хамгаалах яамны сайдын зөвлөлийн хурлаар орж, анхны томилолтоо авчээ. Түүнийг Ардын Армийн 133 дугаар ангийн Удирдах батареины улс төрийн орлогчоор томилсон ба артиллерийн ангид удирдах батарей нь гол үүргийг гүйцэтгэх бөгөөд хугацаат цэргийн алба хаагчдын хувьд ч хамгийн боловсрол өндөртэй нь энэ батарейнд хуваарилагддаг байсан жишээ өнөөдөр ч хадгалагдсаар байна. Тэр л чадварлаг хамт олныг удирдах, мөргөжилд нь сурган дадлагажуулах, тэдэнд эх оронч үзлийг төлөвшүүлэх, үндсэн үүргээ мадаггүй биелүүлэхэд чиглэсэн улс төр, соёл хүмүүжлийн ажлыг өргөнөөр зохион байгуулах зэрэг шинэ шинэ зорилго, зорилтууд байнга дэвшигдэж тэрхүү үүргээ дэслэгч Л.Чулуунбаатар сайн биелүүлжээ. Тэр тухайн үеийн ротын захирагчтайгаа гар, сэтгэл нийлэн ажиллаж, салааны захирагч, түрүүч нарын бүтээлч үйл ажиллагааг дэмжин ажилласнаар зохих үр дүнд хүрсэн. Тийнхүү өдөр, шөнийг үл ялган дайчин, шуурхай ажилласны үр дүнд 1984 онд явагдсан Батлан хамгаалах яамны сайдын нэрэмжит шалгалтаар Артиллерийн хороо нь “Тэргүүн” дүнтэй шалгагдсаны дотор Артиллерийн удирдах батарей “Онц” дүнтэй шалгагдан бусад салбар, нэгжүүдийг манлайлсан. Энэ үеэр явагдсан Байлдааны буудлагатай тактикийн хэргийн сургуулийн үүргийг тус батарей онц дүнтэй биелүүлж, ротын бүх офицерууд хувийн буудлагын дүнгээр онц дүнтэй шалгагдсанаар дивиз, хорооны захирагчаас сайшаагджээ. Мөн дивизийн хэмжээнд зохион байгуулсан марш тактикийн тэмцээнд тус батарей дэд байрт шалгарахад тэр бээр ротын улс төрийн орлогчоор оролцсон нь бахдалтай.

Ийнхүү ажлын амжилт дүүрэн байсан түүнийг Улаанбаатар хот руу шилжүүлэх асуудал яригдан Зэвсэгт хүчний 120 дугаар ангид дивизионы улс төрийн орлогчоор дэвшүүлэх шийдвэр гараад байлаа. Тэр үед хотод тааралдсан Нам, улс төрийн ажлын кафедрын дарга, доктор, профессор, хурандаа С.Баатар “Чи заавал артиллерийн тусгай хороонд очдог нь юу билээ. Сургуулиа онц дүнтэй төгсөж, амжилттай ажиллаж байгаа болохоор чамайг сургуульдаа авна” хэмээн сайд, дарга нарт санал тавьснаар түүнийг Цэргийн нэгдсэн дээд сургуулийн Ар талын ротын улс төрийн орлогчоор томилжээ. Энэ үед ротын захирагч, ахмад Д.Цогт-Эрдэнийн хамтаар олон ч ажлыг санаачлан хэрэгжүүлж, сонсогчдын чөлөөт цагийг үр ашгтай өнгөрүүлэх, тэдэнтэй зохиох соёл хүмүүжлийн ажлыг тогтмолжуулах, сургууль, тэнхимүүдийн хоорондох тэмцээн, уралдаанд баг, тамирчдыг бэлтгэх зэрэг олон ч ажлууд ар араасаа хөвөрсөн ба тэдгээр үүргүүдийг амжилттай биелүүлж чадсанаараа тэр бахархаж яваа. Түүнчлэн 1985 онд ар талын мэргэжлийн сонсогчдын анхны төгсөлтийг зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэн зохион байгуулалтын өндөр түвшинд хэрэгжүүлж чадсан нь бас нэгэн шинэлэг ажил байсныг нь тодотгоё. Тэр бээр дээрх албанд хоёр жил гаруй хугацаанд амжилт дүүрэн ажилласан бөгөөд түүнийг өмнө нь Артиллерийн хорооны Удирдах батареины улс төрийн орлогчоор амжилт дүүрэн ажилласан гэх үндэслэлээр сургуулийн Артиллерийн батареины улс төрийн орлогчоор томилсон тушаал гарчээ.

Тун удалгүй түүнийг 1987 онд Ардын Армийн Ар талыг удирдах газрын Улс төрийн хэлтсийн даргын Хувьсгалт залуучуудын эвлэлийн ажил эрхэлсэн тухлааар дэвшүүлэн томилсон. Захирааны ажилд дөнгөж гаршиж явсан түүнд ийнхүү өндөр итгэлийг хүлээлгэснээр залуучуудын байгууллагаас зохих

ажлыг тогтмолжуулах, харьяа байгууллагуудын ХЗЭ-ийн хороо, үүрийн ажлыг зөв удирдан чиглүүлэх, залуучуудыг зөв үйлд сургах, уриалах, дэмжих, тэдний дунд төрөл бүрийн сонирхолтой ажлуудыг зохион байгуулах зэргээр бахархал дүүрэн ажилласныг нь дурсах ахмадууд олон юм билээ. Түүний нэгэн тод нотолгоо нь Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Төв хорооноос ирсэн шалгалтад амжилттай дүн үзүүлэн “Тэргүүний ХЗЭ-ийн хороо” болсноор илрэх бөлгөө.

“ЦАЙЗ” КОМПАНИЙГ УДИРДАЖ БҮЙ ОН ЖИЛҮҮД

1990 он бол зах зээлийн эдийн засагт шилжсэн хүнд бөгөөд шилжилтийн жилүүдийн эхлэл байсан юм. Энэ үед Ардын Армиас орон тооны цомхотголоор халагдсан олон арван залуучууд иргэний нийгэмд хэрхэн ажиллаж, амьдрах талаар төсөөлөл багатай, орлогогүй шахам байлаа. Түүний хувьд хүүхдүүд нь балчир, эхнэр Ц.Алтай нь ажилгүй болж байгаа гээд сэтгэл зовоох асуудал тулгарсан. Харин энэ үед улсаас хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж эхэлсэн учраас эхнэртэйгээ ярилцан нарийн боовны цөхийг ажиллуулсан нь амжилтад хүрсэн аж. Харамсалтай нь, тэрхүү амжилт нь удаан үргэлжилсэнгүй. Улс орон эдийн засгийн хямралд орсноор нарийн боовны түүхий эдийн олодоц ховордож эхэлсэн бөгөөд өмнөд хөршөөс гурил, элсэн чихрээ татах ажлыг зөв зохион байгуулснаар зах зээлийн хоосон орон зайг нөхсөн төдийгүй хилийн худалдаа болгон өргөжүүлж чадсан нь бас л нэг амжилт байжээ.

Тийнхүү хувийн бизнес нь амжилттай явахын хэрээр өөрийн мэдлэг, ур чадвараа ахиулах, удирдлага, менежментийн арга, ухаанд суралцах, өөрийгөө хөгжүүлэх зайлшгүй шаардлага гарч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Удирдлагын академид 2006-2008 онд суралцан магистрын зэрэг хамгаалжээ.

Харин 2000 онд тухайн үеийн Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, дэд сайд Ц.Тогоо, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал С.Баясанхүү нар түүнд санал тавьснаар БХЯ-ны харьяа “Цайз” улсын үйлдвэрийн газрын даргаар томилон ажиллуулсан юм. Түүнийг ажил авах үед тус үйлдвэрийн газар нь эдийн засгийн хувьд “уналт”-д орсон, улсад 70 гаруй сая төгрөгийн өртэй байжээ. Ийм нөхцөлд удирдлагын зөв менежментийг баримтлан удирдлагын тогтолцоог өөрчилж, байнгын хяналт, өдөр тутмын үйл ажиллагааг жигдрүүлснээр 2001 онд Батлан хамгаалах яамны “Тэргүүний аж ахуйн нэгж”-ээр шалгарч, тэр жилээ Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Тэргүүний байгууллага” болсон амжилтыг түүний хөдөлмөрч, бүтээлч үйл ажиллагаатай нь холбох учиртай. Тэр ч чанараараа түүний хөдөлмөр, зүтгэл, өдөр тутмын шуурхай ажиллагааны үр дүнд өр, авлагагүй байгууллага болж, БХЯ-ны “Тэргүүний аж ахуйн нэгж”-ээр 2002 онд дахин шалгарсан нь та бидний бахархлыг зүй ёсоор хүлээх биз ээ.

Гэтэл Засгийн газрын тогтоолоор Батлан хамгаалах яамны “Цайз” улсын үйлдвэрийн газрыг 2002 онд хувьцаат компани болгон хувьчлах, нийтийн дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гарсан байна. Энэ үед тэр бээр үр байгууллагыг хөл дээр нь босгож, тэргүүний аж ахуйн нэгж болгосон, нөгөө талаар энэ байгууллагад өөрийн сэтгэл, зүтгэлээ нэгэнт зориулсан болохоор иргэний эр зориг гарган нийтийн дуудлага худалдаанд оролцсон 10 гаруй аж ахуйн нэгжээс хамгийн өндөр үнээр үр байгууллагаа худалдан авсныг нь түүх гэрчлэх биз. Ингэснээр өнгөрсөн хугацаанд “Цайз” ХХК-ийг хууль, эрх зүйн хүрээнд зөв менежментээр удирдах, нийтийн эрх ашгийг хамгаалах, нийслэлийн иргэдийг мод, модон бүтээгдэхүүн, барилгын материаллаар хангах, хамгийн гол нь иргэдийг ажлын байртай байлгах, тэдний хөдөлмөрлөх нөхцөлийг нь бүрдүүлэх талаар ихээхэн санаачилга гарган ажилласаар байна.

Тус компани нь Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Тэргүүний аж ахуйн нэгж”-ийн шагналыг 2002-2007 онд таван жил дараалан хүртсэнийг түүний ажил хэрэгч, бүтээлч хөдөлмөртэй нь холбон тайлбарлах учиртай. Харин тэр өөрөө тус дүүргийн 2005 оны хөдөлмөрийн аварга тодорч, 2006 онд “Монголын менежерүүдийн холбооны шилдэг захирал”-ын өргөмжлөл, цомыг хүртсэнийг нь онцолж буй минь энэ.

Ийнхүү түүний ажил, амьдралын сайн сайхныг өгүүлсэн олон арван баримтыг нь нэн тодорхой дэлгэх учиртай ч сонины зай, уншигч таны цагийг хэмнэж энэхүү нийтлэлдээ түр цэг хатгаж.

Тийм ээ! Түүний ажил, амьдралын дардан зам нь сүүн мөртэй бөлгөө ...

МСНЭ-ийн шагналт сэтгүүлч, СТА, хурандаа Б.ОТГОНБАЯР



анги, салбаруудад үлгэр жишээчээр ажиллаж, олон арван шалгуур үзүүлэлтийг давснаар ирээдүйн дарга, захирагч нарын толь нь болсон шижигнэсэн офицерууд байсан. Тэдний нэг нь шулуун шударга зантай, ажил хэрэгч бөгөөд улс төр, хүмүүжлийн ажлыг жинхэнэ утгаар нь зохион байгуулдаг, цэмцгэрхэн ахмад Л.Чулуунбаатар байсныг бид өдгөө ч шагшин магтсаар байдаг юм. Түүний ажил, амьдралын талаар тодотгон өгүүлж буй нь энэ бөгөөд уншигч танд ч нэгийг бодогдуулах биз ээ.

ХҮҮХЭД НАСНЫХ НЬ ХӨГЖӨӨНТ ЖИЛҮҮД

Л.Чулуунбаатар 1961 оны зун Улаанбаатар хотноо мэндэлсэн бөгөөд түүний бага нас бусад хүүхдүүдийн нэгэн адилаар гэр болон цэцэрлэгийн хүмүүжлээр өрнөж, аав, ээждээ тус болохыг хичээн мод, түлээ бэлтгэх, ус авах, гэр орноо цэвэрлэх гээд олон ч ажилд зүтгэж, бага наснаасаа “хөдөлмөрч хүү” хэмээгдэн тэднийхээ магтаал үгэнд урамшиж өссөнөөр тодорхойлогдоно. Тэднийх одоогийн “100 айл” хэмээх газарт амьдарч байсан бөгөөд бидний үеийн хүүхдүүд эцэг, эхийн үгнээс гажна гэж үгүй, өөрт

байдаггүй боловч тухайн үеийн ангийн дарга С.Уранчимэг, бүлгийн дарга Х.Мөнхцэцэг, гавьяат тамирчин, чөлөөт бөхийн олон улсын шүүгч Адуучийн Баасанхүү, Худалдаа, хөгжлийн банкны дэд захирал Ч.Хүрэлбаатар, “Насны зам” компанийн захирал Ж.Энхжаргал, хоёрдогч түүхий эдийн “Судалт төв”-ийн захирал Ц.Түмэнжаргал нарын олон найзуудтайгаа байнга л холбоотой байж, ажил, амьдралын жаргал, зовлонгоо хуваалцаж явааг нь энд тодотгоё.

СОНСОГЧ ҮЕИЙН БАХАРХАЛТ ЖИЛҮҮД

Л.Чулуунбаатарыг 10 дугаар ангид орсон жил аав, ээж хоёр нь “Хүү минь ах, эгч нар чинь бүгд л их, дээд сургууль төгсөөд сайн сайхан ажиллаж, амьдарч явна. Миний хүү тэднийхээ залгамж болж, бас хэдэн дүү нартаа үлгэрлэл үзүүлэхийн тулд дээд сургуульд суралцах нь зөв. Гадаад, дотоодын цэргийн дээд сургуулиуд байдаг юм байна. Тэр сургуульд суралцаж, цэргийн хүн болбол яасан юм бэ?” хэмээн зөвлөжээ. Тэрээр 10 жилийн сургуулиа өндөр хувьтай сайн үнэлгээтэй төгссөн ба гадаадын

НИСГЭГЧ, ТЕХНИКЧ ХОЁР

ХОВОР ТОХИОЛДООР ХҮРТЭСЭН ЦОЛ

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн захирагчаар ажиллаж байсан, бэлтгэл хурандаа Бадамдоржийн Лувсандорж гуайтай уулзахаар Налайх дүүргийг зорив. Зэвсэгт хүчний Инженерийн цэргийн тусгай хорооны ойролцоо ханаа шийрлэсэн буурал хурандаа маань "тэтгэвэр буусан, сарынхаа хоол хүнсийг базааж яваад ирлээ" гэсээр угтан золголоо. Түүний уугуул нутаг усных нь талаар ярилцлагаа эхлэв.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын уугуул. Манай сумын дарга Аварзэд гэж улс даяар нэр алдар нь түссэн, сайхан баатар байлаа. 1973 онд сумандаа 10 дугаар анги төгссөн. 1975 онд цэрэгт ирээд Хүндэт харуулын цэрэг боллоо.

1976 онд ЗХУ-ын Нисэхийн дунд сургуульд явж, "МиГ-17" сөнөөгч онгоцны нисгэгчээр төгсөж ирсэн. Жалбаагийн Мөнхсайхан, Сэмжидийн Алтангэрэл, Хангай гээд бид дөрвүүлээ очоод Хангай маань төгсөж чадаагүй. Бид гурав 1979 онд сургуулиа төгсөөд 137 дугаар ангид нисдэг тэрэгний 109 дүгээр ангид нисдэг тэрэгний 2 дугаар нисгэгчээр томилогдож, Л.Пүрэвсүрэн гавьяатын шавь болсон. 1984 онд Төв аймгийн Алтанбулагт Байлдааны нисдэг тэрэгний 251 дүгээр ангид нислэг эрхэлсэн орлогч буюу Баатарчулууны Болд даргын орлогч болсон.

1988 онд ЗХУ-д Гагарины нэрэмжит Нисэх хүчний академид суралцаж 1991 онд төгсөж ирсэн. Төрөлх ангидаа Байлдааны нисдэг тэрэгний захирагчийн орлогч, Байлдааны нисдэг тэрэгний захирагч, хорооны захирагчийн улс төрийн орлогч, нислэг эрхэлсэн орлогч, 1998 онд хорооны захирагч болсон. Дараа нь Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалд Сөнөөгч онгоцны байцаагч нисгэгчээр очоод 2001 онд тэтгэвэрт гарсан.

Түүнээс хойш Налайхаар бага сага хөдөлмөр эрхэлж байгаад Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид 5 жил ажилласан. Худгийн моторчин, харуулын дарга хийлээ. 2008 онд 137 дугаар анги ОХУ-аас шинэ нисдэг тэрэг авсан. ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажав дуудаж "Ангидаа нислэгийн удирдагчаар очно уу, цолыг чинь сэргээхгүй, энгийнээр ажиллуулъя" гэсэн. Ангидаа эргэж очоод 8 жил нислэг удирдсан. 2014, 2015, 2016 онд Монгол Улс, ОХУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан "Сэлэнгэ" сургуульд нислэг удирдаж явлаа.

Нислэгийн удирдагч бол онгоц, нисдэг тэрэгний аюулгүй байдлыг хангах чухал ажил. 2017 онд нас жар ч хол гарчихлаа, тэтгэвэрээ эдлээд сууя даа гэж бодоод гарсан.



Кишанкинтай нисэж байсан. Газардаж яваад хөөрөхийн даваан дээр урд дугуй хагарчихлаа. Урд дугуй хагарна гэдэг чинь тийм хурдтай онгоц шатна шүү дээ. Багш нисгэгч маш хурдан гар тормосоо татаад яаралтай гар гэсэн. Хоёулаа онгоцноос буугаад харайлгалаа. Тэр хооронд эргэж харахад урд дугуй дороосоо шатаж байсан. Дугуйнд агаарын болон хүчилтөрөгчийн баллон гэж байдаг. Түүнд гал авалцвал тэгээд л дуусна. Тэр хооронд амжиж хоёулаа гарсан. Галын тэрэг ч цаг алдалгүй ирж галыг унтраасан.

Бас нэг удаа нисдэг тэргэн дээр Л.Пүрэвсүрэн гавьяаттай Ховдын Алтай руу код хүргэх нислэгт явсан. Говь-Алтайн төвөөс хөөрөөд 4000 орчим метрийн өндөртэй даваануудыг давж явтал салхинд цохиулсан. Ямар ч удирдлага байдаггүй. Би залуу нисгэгч байсан болохоор тэвдсэн. Нисдэг тэрэг маань өндөр уул руу хажуу бөөрөөрөө яваад байдаг. Багш руу харвал ихэд тайван, сүрдсэн шинжгүй байна. Болдог л юм байлгүй гээд жаахан ч гэсэн тайвширлаа. Тэгтэл ашгүй агаарын урсгалд ороод удирдлагатай болов. Тэр уул руу их дөхсөн. Ер нь л "наах" шахсан шүү.

Тэгж л хоёр удаа эрсдэлтэй нөхцөлд орсон. Багш нисгэгчидтэй явж таарсан, тэдний маань ур чадвар байсан байх. Эхэнд дурдсан "МиГ-17" дээр гэхэд орос багш нисгэгч, ахлах дэслэгч залуу байсан. Нисдэг тэрэгтэй нисэж агаарын урсгалд цохиулахад гавьяат нисгэгч Л.Пүрэвсүрэн дэд хурандаа цолтой байсан санагдана.

251 дүгээр ангид байхад Байлдааны нисдэг тэрэг "Ми-24в"-ээр 1987 онд анхны нислэг хийсэн. Би Леонтов хэмээх мэргэжилтэнтэй

Галхүүгийн Сарангэрэл, Дамбын Цогтсайхан нараар бахархаж явдаг. Самбуугийн Шаравсамбуу, Балсамбуугийн Лхагвасүрэн, Лувсанцэрэнгийн Дорж, Мандахын Билгээ гээд ангийн захирагч хийж байсан алдартай сайхан нисгэгч нар байна. Бас Пунцагийн Эрхэмбаяр мундаг нисгэгч байлаа. Тэдний гаргасан зам мөрөөр л бид замнасан.

1987 онд Зүүнбаянд ахлах офицеруудын цугларалт болсон. Тэнд хоёр орос нисгэгчтэй хамт манай тактик, галын бэлтгэлийн дарга байсан Жанчивын Ёндон бид хоёр нисдэг тэргээр үзүүлэх нислэгийг анх удаа хийсэн. "Ми-24в" гэдэг нисдэг тэргийг арми даяар мэддэггүй байлаа. Тэгэхэд хоёр нисдэг тэрэгтэй очиж полигонд пуужин харваж нислэг хийж байсан. Ж.Ёндон генерал БХЯ-ны сайд байсан. Бидэнд баяр хүргэж гар барьж байсныг мартдаггүй.

1999 онд би ангийн захирагч байлаа. БХЯ-ны газрын дарга П.Алгаа хурандаа манай ангид ирж "Ирэх хагас сайн өдөр Ерөнхий сайд танхимынхаа гишүүдтэй танай энд салхинд гарна. Та нар асар, майхан барьж өгнө шүү" гэлээ. 318 дугаар ангийн захирагч Батдэлгэр хурандаагаас герман ногоон асар авч барьсан. Ерөнхий сайд Р.Амаржаргал, сайд нартайгаа ирлээ. "Зэвсэгт хүчний 137 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Лувсандорж" гээд илтгэлээ. Манай сайд Ш.Түвдэндорж сүүлд ирсэн. Ерөнхий сайдыг ирсэн дээр нэг ч гэсэн асуудлаа шийдвэрлүүлээр санагдаад болдоггүй. "Городок гэж орон сууцны хотхон манай ангийн харьяанд байдаг юм. Жил бүр хөлддөг, цахилгааны зардал нь хаанаа ч хүрдэггүй. Мөн хоёр нисдэг тэрэгний засварын зардал 240 сая төгрөгийг шийдэж өгнө үү" хэмээн танилцуулав. Сангийн сайд Очирхүүтэй ярь гэлээ.

Тэгснээ Ерөнхий сайд "Танд хурандаа цолны зэрэглэл байдаг уу" гэж байна. "Байгаа, намраас олгох байх аа" гэлээ. Тэгсэн Ерөнхий сайд "Танд хурандаа цол өгье. Зүүж ирээд илтгэ" гэв. ЗХЖШ-ын даргын тушаалаар л хурандаа цол олгодог журамтай даа гэж бодогдож, дотроо эргэлзэж байлаа. Тэгсэн манай хоёр орлогч ханцуйнаас татаж "Захирагч аа цолоо зүүгээ" гээд болдоггүй.

Орлогч нар маань миний савхин куртик дээрээс цолны хоёр тэмдгийг авч мөрдэс дээр нэмж зүүж өгөөд Ерөнхий сайд руу очиж илтгэ гэлээ. Ороод илтгэхэд Р.Амаржаргал сайд цэргийн хүн байсан болохоор босож зогсоод илтгэл авч баяр хүргэлээ. Бусад сайд нар ч баяр хүргэж байна. Үдийн алдад Ш.Түвдэндорж сайд ирлээ. Сайдад болсон явдлыг илтгэлээ. "Би мэдсэн" гэж байна. Сайд нарын унаа цуваа татаад хөдлөхийн алдад сайд намайг дуудаад "Нэг дэх өдрөөс Таны хурандаа цолны тушаалыг гаргана. Захирагч болсноосоо хойш хийсэн ажлаа бичээд өгөөрэй" гэсэн.

Даваа гарагийн өглөө ангийн нийт бүрэлдэхүүн нэгдчихээд байдаг. Хурандаа цолтой гарч болох, үгүй мэддэггүй. Өрөөндөө хэсэг суулаа. Тэгээд ЗХЖШ-ын даргын туслах руу утас залгаж, Ерөнхий сайд надад хурандаа цол олгосон юм. Ангийн бүрэлдэхүүн нэгдчихээд байдаг. Шинэ цолтой гарч болох, эсэхээ мэдэхгүй байна. Даргаас асуугаад өгөөч гэлээ. 15 минутын дараа даргын туслах утасдаж "Таныг хурандаа цолтой гарч болно гэж байна" гэв. Тэгж нэг нүүр бардам гарлаа. Баасан гарагийн орой ажил тарахад дэд хурандаа байсан хүн Даваа гарагийн өглөө хурандаа болчихсон байдаг. "Өдрийн сонин"-ы дугаарт Ерөнхий сайд Р.Амаржаргал ангийн захирагчид хурандаа цол олголоо гэж бичигдсэн байсан.

Б.Лувсандорж хурандаагийн яриаг нэмэр хачиргүй сийрүүлээ. Түүний гэргий Нямсүрэнгийн Гэрэлсүрэн гэдэг. Тэрээр Налайх дүүргийн Шүүхийн байгууллагад олон жил хөдөлмөрлөөд өдгөө гавьяаны амралтаа эдэлж буй ажээ. Тэднийх гурван хүү, нэг охинтой. Хүүхдүүд нь ээж, аавынхаа нэр алдрыг өндөрт өргөж, улс нийгэмдээ сайн сайхан ажиллаж, амьдарч яваа ажээ.

Сөнөөгч онгоцны анхдагчуудын нэг радиоэлектрон тоноглолын техникч асан бэлтгэл дэд хурандаа Гэлэжамцын Зэвэг гуайтай уулзлаа. Тэрээр 1968 онд Сүхбаатар аймгийн төвийн 10 жилийн сургууль төгсөөд МУИС-ийн физикийн ангид элсэн суралцжээ. Гэтэл нэгдүгээр курсээс цэрэгт татагдаж 028 дугаар ангид хуваарилагдсан аж.

1970 онд цэргийн сургуульд явахаар шалгалт өгч тэнцлээ. Анхны хуваарь нь Львовын Цэргийн улс төрийн дээд сургууль байв. "Би улс төрийн ажил сонирхдоггүй. Өөр ямар сургууль байна гэсэн. Нисэхийн дунд сургуулийн радиогийн анги байна гэхээр нь явах



НАЙРААГҮЙ ЗЭВЭГ ИНЖЕНЕР

хүсэлтээ илэрхийлсэн. Их сургуульд үзэж байсан физикийн мэргэжилтэй оролцоо юм гээд сонирхлын дагуу явахаар шийдсэн. Тэгэхэд нисэхийн сургуульд явах хүмүүсийг гавьяат нисгэгч Д.Цэрэндорж гуай бүртгэж байсан. Тэрээр "Чам шиг дээд сургуулиа дунд сургуулиар сольдог хүн байдаг юм уу гэж билээ" хэмээн Г.Зэвэг гуай дурсав.

Ингэж радиоэлектрон тоноглолын анхны техникч нар болох хувь заяаны эзэд болох Намжилзавын Энэбиш, Лувсандаваагийн Галбадрах, Гэлэжамцын Зэвэг гурав хуучнаар ЗХУ-ын Краснодар хотыг зорилоо. Тэнд сурч байсан Жүгдэрийн Борхүү, Жанчивын Пүрэвээ хоёр нислэгээс хасагдаж, дээрх гуравтай "ам бүл" нэгдэв. "Радио"-ийн анхны гурав хожим цэргийн академи төгссөнийг дурдахад илүүдэхгүй. Тэд Краснодарын Нисэхийн нэгдсэн дунд сургуульд номыг нь чамгүй үзэж, ногоотой шөлийг нь уулаа. Хоёр жил суралцаж 1972 оны өвөл сөнөөгч онгоцны радиоэлектрон тоноглолын техникч мэргэжлээр төгсөв. Манай улс "МиГ-17", "УТИ-15" гэсэн хоёр загварын онгоцтой байсан үе. Техникчид ирээд ажиллаж байтал удалгүй Г.Зэвэг үйлчилгээний радиогийн группийн даргаар томилогдов. Түүний бүлэг онгоцыг нислэгт бэлтгэх үүрэгтэй.

"Оросын мэргэжилтэн сайхан хүн байсан. Нэрийг нь мартаж орхижээ. Тэр үеийн мэргэжилтнүүд жинхэнэ

хүртэл ажиллав. Дараа нь байлдааны нисдэг тэрэгний 251 дүгээр ангид цахилгааны инженерээр томилогдсон аж. Алтанбулагт очоод жил ч болоогүй байтал тус анги Налайхад шилжин байрлав. Тэгээд нисэхийн хоёр анги нэгдэхэд Зэвэг мэргэжлийн дагуу инженерээр ажилласан байна.

Алба хааж байхдаа тохиолдсон нэгэн явдлыг сонирхуулав. Онгоцонд цаг агаарын нөхцөлөөс хамаарч цанталтаас хамгаалах цэвэр спирт олгодог. Нисгэгч бууж ирээд ашигласан бол баримт бичиж зарлагдаж журамтай. Бусад замаар спирт алдагдаж байна гэсэн яриа гарч няравыг нь солихдоо тулав. Архи уудаггүй хүн гэдэг шалгуураар Зэвэгээр тавихаар тохирчээ. Нэг өдөр бие бүрэлдэхүүний хурал хийж байгаад сүртэй нь аргагүй түүнийг няраваар томиллоо.

Сар боллоо. Хүмүүс янз бүрийн л шалтгаанаар спирт авахаар ирнэ. Та нар даргын цохолт л авчир гээд гэдөггүй байв. Нэг өдөр Төөрүүл Зэвэгээр тавихаар ороод ирлээ. Тэрээр намайг спиртын няраваар тавилаа гэж байна. Дарга нар томилсон юм байх аа. Г.Зэвэг "Сүртэй ярьж тавихаар авахдаа чимээгүй авдаг юм байна" гэж хэлжээ. Гол шалтгаан нь найраагүй нөхөр юм гээд өөр хүн тавихаар шийдсэн юм билээ. Би ч дуртай өгсөн. Ийм ч хүн явуулсан, тийм ч шалтгаан байна гээд салдаггүй байсан гэж тэрээр хөгжилтэй өгүүлэв.



Техникч Г.Зэвэг сөнөөгч онгоцон дээр

алтан гартнууд байсан. Надад бүх зүйлийг зааж 1979 он хүртэл ажилласан. Тэрээр надад "Радиогийн техникч хүн зөөлөн гартай байх ёстой. Чиний гар дэндүү чанга байна" гэдэг байлаа. Юм эвдээд байна гэж л хэлж байгаа нь тэр. Радиогийн антенн гэж байх. Мэргэжилтэн маань "Антенн ажиллахгүй байна. Чи нэг үзээтэх" гэлээ. Контакт нь хөндийрчихжээ гэхэд, тэрээр сайн байна, засчих гэв. Хөндийрсэн контактыг нийлүүлэх санаатай жаахан татсан чинь хураарчихсан. Тэгээд л намайг хатуу гартай гэж зэмлэсэн.

Радио тоноглолын инженер гэдэг чухал мэргэжил. Радиогийн бүлгийн дарга байхдаа онгоцны нислэгийн урьдчилсан болон нислэгийн дараах үзлэгийг хийнэ. Урт, богино долгионы радио, навигагийн станцууд, радиолокаторын үйл ажиллагааг шалгана. "Радиомаяк" гээд онгоцны курсийг тодорхойлдог багаж байх. Тэдгээрийг шалгаж бэлэн байдлыг хангана гээд энэ мэргэжлийн хүмүүсийн үйл ажиллагаа нарийн чимхлүүр, хариуцлагатай ажил юм.

Г.Зэвэгийг бүлгийн дарга байхад мэргэжил нэгт техникч Борхүү, Галбадрах, засварын бүлгийн дарга Энэбиш, Краснодарын мекхикчийн курс төгссөн Хишигсүрэн, Сүхээ, Тэрбиш, Баасан гээд олон цэргүүдтэй нэг чиглэл, зорилгын төлөө зүтгэж явжээ.

Түүнийг бүлгийн дарга байхад "МиГ-17"-гоос "МиГ-21" рүү шилжих сургалт явагджээ. Энэ чухал сургалтыг төгсөөд 1979 онд шалгалт өгч Жуковскийн академид явав. Уул нь 5 жил сурах ёстой. Хэлний бэлтгэлгүй орсон учраас 4 жил суралцжээ. 1983 онд академид цахилгаан тоноглолын инженер мэргэжлээр төгсөж иржээ. 137 дугаар ангидаа автоматикчийн инженерээр томилогдож 1989 он

1990 онд ЗХЖШ-т авиачин инженерийн орон тоо гарав. "Намайг энэ албанд томилсон. Удалгүй армийн цомхотгол эхэлсэн. Миний орон тоо цомхотголд орсон тул 109 дүгээр ангид штабын даргаар явах уу гэсэн. Мэргэжлээрээ ажиллахгүй юм бол тэтгэвэртээ гаръя гээд 1991 онд тэтгэвэртээ гарсан. Армид 23 жил ажилласан" гэж Г.Зэвэг гуай өгүүлэв.

Тэтгэвэртээ гараад хийх ажилгүй хэсэг суусан. "Залуу жанжны" хүү Лхагваа хурандаа "Хангарьд" нэртэй нисэхийн компани байгуулж, түүнийг техникийн захирлаар ажиллау уу гэж урьжээ. Урилгаар 8 жил орчим ажиллав. Энэ хугацаанд 2000 онд Казахстан болон Энхийг сахиулахын хэргийн сургуульд очсон монголын цэргийн багийг тус компанийн нислэгээр хүргэж өгсөн байдаг. Харамсалтай нь зарим улс төрчдийн явуулгаар Хангарьдын онгоцуудыг нисгэхгүй шахалт үзүүлж эхэлжээ. Гол нь өөр нисэхийн компани байгуулж үйл ажиллагаа явуулах явцуу зорилготой байсан юм билээ. Эцэст нь арга буюу Зэвэгийн ажиллаж байсан компани үйл ажиллагаагаа зогсоов.

Ингээд ажилгүй хэсэг суужээ. Түүний охин америк залуутай ханилсан юм. Тэгсэн нь тэд Америкт ирж амьдрах уу гэжээ. Монголдоо ажил байхгүй юм чинь тэгье гээд далайн чанадыг зорив. Хүүхдүүд нь их, дээд сургуульд сурч байсан болохоор тэднийхээ сургалтын төлбөрийг олох зорилго тавьжээ. 2005 онд Г.Зэвэг гэр бүлийн хамт Америкт очиж, 2018 оныг хүртэл амьдарчээ. "Боолын хөдөлмөр эрхэлсэн дээ. Дэлгүүр цэвэрлэсэн, хуас ч барьж үзлээ, сүүлийн 7 жилд нь пицца зөөх ажил хийсэн. АНУ-д 12 жил амьдраад Монголдоо эргэн ирж төвхнөсөн" гэж тэрээр ярьсан.

Нүүрийг бэлтгэсэн бэлтгэл хурандаа Г.НЯМДОРЖ



Ю.А.Гагарины нэрэмжит Нисэх хүчний академийн сонсогч, ахмад Б.Лувсандорж

"Л-29", "МиГ-17", "МиГ-15", "МиГ-21", нисдэг тэрэг "Ми-8", "Ми-24в" гээд нэлээд хэдэн онгоц, нисдэг тэрэгээр ниссэн. Нийтдээ 1300 гаруй цагийн нислэг хийжээ. Сөнөөгч онгоц хурдан нисдэг учраас нислэгийн цаг сүртэй нэмэгддэггүй юм. Иргэний агаарын онгоцнуудтай огт адилгүй. 1300 цаг гэдэг бол сөнөөгч онгоц болон нисдэг тэргэн дээр чамгүй хугацаа. Олон онгоцоор ниссэн гэсэн гавьяа шагнал байдаггүй юм. Гурван жилийн өмнө Цэргийн гавьяаны одонгоор шагнагдсан. Хошууч генерал Р.Сүхбат, Ж.Бадамбазар нар надад одон зүүж өгөхдөө "Лууяа ах, яасан орой явж байх юм бэ" гэж байсан. "Ажил, алба хийж явахад надад өгөөгүй л юм даа" гэсэнд инээлдэж л байсан.

1979 онд сургуулиа төгсөж байхад нэгэн тохиолдол болсон. "МиГ-17" онгоц дээр багш нисгэгч

09 дугаартай нисдэг тэрэг дээр ниссэн. Хэд хоног оросуудтай нисээд багш нисгэгч болж, ЗХУ-д төгсөж ирсэн залуучуудаа дадлагажуулж эхэлсэн. Өдгөө 337 дугаар ангийн захирагчийн нислэг эрхэлсэн орлогчийн алба хашиж буй хурандаа Н.Баясгалан гээд миний шавь олон бий.

Ангийн захирагчаар ажиллаж байхдаа 2000 оны 9 дүгээр сард ангийнхаа 30 жилийн ойг хийсэн. Түүндээ бахархдаг юм. Гол ус дагахгүй гээд ангийнхаа баруун талд тэмдэглэсэн. Ахмадууд маань сайхан боллоо гэж байсан. Тэр үед манайх нислэггүй болсон байсан. Бусад сургалт, зохион байгуулалтын ажил хэвийн, тасралтгүй явагдаж байсан.

Сөнөөгч онгоцны анхны дөрвөн нисгэгч Төмөрийн Пүрэвдорж, Сэржмандалын Усник,



ОХУ-ын мэдээллийн хамгийн том агентлаг болох "ТАСС"-ын цахим хуудсанд 11 дүгээр сарын 13-ны өдөр цэргийн ажиглагч, мэргэжилтэн Дмитрий Литовкинийн бичсэн томоохон хэмжээний зэвсэгт мөргөлдөөн, дайн гарах үндэслэлтэй эсэх, гарвал юунаас болох талаарх нийтлэлийг орчуулан хүргэж байна.

ДЭЛХИЙН ШИНЭ ДАЙН

ЯАГААД ЕВРОПЫГ ТҮГШЭЭЖ БАЙНА ВЭ?

Эхлээд Их Британийн Батлан хамгаалахын Штабын дарга Ник Картер, дараа нь Чехийн Тагнуулын алба өөрсдийн жил бүрийн эцэст гаргадаг тайландаа хүн төрөлхтөн дэлхийг хамарсан дайны аюулд дөхөж байна хэмээн мэдэгдсэн. Ник Картерын илтгэлд уг аюулын шалтгаан нь "түгшүүр болон тодорхойгүй байдал" гэж дүгнэсэн байна. Мөн түүний хэлснээр "бүс нутгийн маргаан, зөрчилдөөн" нь асуудлыг улам бүр дэвэргэж байгаа аж. Харин Чехийн тагнуулын албаны тайланд дурдагдсан зүйлс нь илүү тодорхой асуудлуудыг тусгасан юм. Тэдний үзэж байгаагаар дэлхийн дайн гарах гол үндэс нь "дэвшилтэт технологийг урвуулан ашиглахаас үүдэлтэй байж болзошгүй" талаар бичжээ. Мөн цахим орчин дахь халдлага эсвэл нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн дайралтууд нь дайныг өдөөгч гол хэрэгсэл нь болж, олон улсын дүрэм, журмыг үл хэрэгсэх хандлагаар явагдах магадлалтай гэнэ.

"FALLOUT" БУЮУ УРЬДЧИЛСАН МЭДРЭМЖ

Англи хэлний "Fallout" хэмээх үг нь орос хэлэнд маш олон утгаар илэрхийлэгддэг. Гэхдээ хамгийн ойр утга нь "кранты" буюу "аливаа зүйлийн харамсалтай төгсгөл"-ийг илэрхийлсэн орчин цагийн гудамжны хэллэгтэй их дөхнө. Энэ нөхцөлд цөмийн зэвсгийн мөхлийн дараах амьдралыг хэлнэ. Тус нөхцөл нь АНУ болон хөгжингүй орнуудад мэдээжийн сэдэв гэдэг нь илэрхий болсон.

XIX зууны 1960-аад оны үед америкчууд цөмийн бөмбөгийн цохилтоос хамгаалсан хоргодох байруудад ихээхэн анхаарал хандуулж, олноор нь барих болсон. Харин ЗХУ-ын хувьд цөмийн цохилтоос хамгаалсан дадлага, сургуулийг ихээр явуулж байлаа. Тухайлбал, энэ үед амьдарч байсан хүмүүс сайн санах буй заа. Юу гэвэл "зүүн гар талд чинь ямарваа нэгэн зүйл анивчих аваас баруун тал руугаа хэрхэн зөв унаж, толгойгоо гаргаараа хаахыг сургаж байсныг. Хамгийн инээдтэй нь дээрх дадлага, сургуулийг хэчнээн удаа давтаж зөв хийсэн ч цөмийн бөмбөгийн цохилтоос амьд үлдэхгүй нь тодорхой юм.

Ник Картерын тайланд "Бүс нутгийн хэд хэдэн зөрчилдөөн нэгэн зэрэг давхцах эрсдэлтэй байна. Ийм зөрчилдөөнүүдийг багцлан авч үзэх нь зарим асуудлуудад дүгнэлт гаргахад учир дутагдалтай. Бид өөрсдийн эрх ашгийг хамгаалах ёстой. Гэхдээ зарим асуудалд бид хэтэрхий нэг талыг барьсан байж магадгүй" хэмээн бичжээ. Мөн "Өнгөрсөн зуун жилд ийм алдаанаас болж хүн төрөлхтөн хоёр удаа дайн хийсэн бөгөөд шийдвэр гаргагчид заримдаа өөрсдийн үйл ажиллагааны дараах үр дагаврыг ойлгодоггүйгээс хурцадмал байдлыг үүсгэдэг. Энэ нь улам бүр олон орныг цэргийн мөргөлдөөнд татан оролцуулдаг. Ингэснээр үйл явдлыг зогсоход аль хэдийн оройтож дайны хэмжээнд хүргэдэг" гэж Картер онцолжээ.

Чехийн тагнуулын албаны мэдээнд "Улс орнууд дайнд бэлтгэх эхний шатандаа явж байна. Энэхүү үйл явц нь иргэдийнхээ бодол санаанд нөлөөлөх хэлбэрээр харагдаж байгаа юм. Хэрэгжүүлэх техникийн арга, хэрэгсэл нь харилцан адилгүй байгаа ч зорилго нь нэг гэж хэлж болно. Хэрэв бид өөрсдийн үйл ажиллагааны сөрөг үр дагаврыг урьдчилан таамаглаж зөв үнэлэх чадваргүй бол алдаатай зааварчилгаа, тушаал нь бүс нутаг болон олон улсын



маргаанд эргэлт буцалтгүйгээр татан оруулж болзошгүй" хэмээн бичжээ.

НҮДЭНД ЗОРИУЛСАН НҮД

Болзошгүй асуудлын шинж тэмдгүүд өнөөдөр үнэхээр олон улсад илт мэдрэгдэж байна. Тухайлбал, Хойд Атлантын эвслийг өргөжүүлэх хүрээнд Европ дахь "Энгийн зэвсгийн тухай" гэрээ цуцлагдсан. Энэхүү гэрээ нь ОХУ-тай хил залгаа Балтын тэнгисийн орнууд дахь бүс нутгийн зэвсгийн харьцааг зохицуулж байв. Уг гэрээг хүчингүй болгосноор дунд болон богино зайн тусгалтай пуужингуудыг хилийн дагуу байрлуулж ОХУ-ын томоохон хот, үйлдвэрүүд рүү чиглүүлэх бүрэн боломжтой болсон.

Ийм нөхцөлд оросууд ч зүгээр суухгүй нь хэнд ч ойлгомжтой. Жишээлбэл, Далавчит пуужин бүхий оператив-тактикийн цогцолбор "Искандер-М"-ийг Калининградскийн тойрогт байрлуулж магадгүй юм. Мөн "МиГ-31" загварын нисэх онгоцуудтай нисэх баазуудыг өндөр уулын бүсүүдэд байршуулснаар бүхий л Европт хяналтаа тогтоох боломжтой.



МиГ-31

Аль хэдийн Өмнөд цэргийн тойргуудад байрлах анги, салбаруудыг шинэ үеийн тоон систем бүхий "Кинжал" орчин үеийн дуунаас хэт хурдан пуужингаар хангаж эхэлсэн нь нууц биш юм.

ОХУ-АНУ хоорондын байгуулсан цөмийн зэвсгийг бууруулах гэрээний хугацаа дуусаад багагүй хугацаа өнгөрлөө. Энэ гэрээг сунгах бичигт Дональд Трамп сонгуулийн өмнө гарын үсэг зурж зүрхлээгүй. Учир нь түүнийг Оросын талыг баримтлагч гэж иргэд нь буруутгана гэж бодсоноос үүдэлтэй хэмээн ажиглагчид дүгнэсэн. Мөн Жон Байден хүртэл уг баримт бичигт гарын үсэг зурахгүй байх талтай. Учир нь АНУ нь өөрсдийн цөмийн зэвсэглэлийн хүчийг шинэчлэх ажилд аль хэдийн 1.5 их наяд долларын хөрөнгө оруулалтыг хийчихсэн бөгөөд ирэх 30 жилийн хугацаанд цөмийн шумбагч "Огайо"-г шинэ загварын

"Колумб" цөмийн шумбагчаар, 400 гаруй хуучирсан "Minute-man-3" загварын цөмийн хошуу тээвэрлэгчийг шинэ загварын техникээр солихын зэрэгцээ Агаарын хүчин нь "B-21 Raider" бөмбөгдөгч онгоцнуудыг хүлээн авах төлөвлөгөөтэй байгаа нь цөмийн зэвсгийн үйл ажиллагааг хориглох баримт бичигт гарын үсэг зурахаас зайлсхийхэд хүргэж байна.

Дээр хэлсэн шинэ төрлийн техник, хэрэгслээс гадна АНУ-д дуунаас хурдан цөмийн цогцолбор "Авангард", дэлхийн аль ч цэгт мегатонн цөмийн бөмбөгийг хүргэх чадвартай хүнд даацын баллистик пуужин "Сармаг" байгаа ч Америкийн цэргийнхэн болон энгийн иргэд гаднын довтолгооноос айх айдасгүй амьдарч байгаа гэсэн үг биш юм. Оросуудын хувьд цөмийн зэвсгийн тоог бууруулах гэрээг цааш үргэлжлүүлэхэд ямар ч асуудалгүй хэмээн илэрхийлж байгаа бол америкчуудын хувьд энэ салбарт дэндүү олон ажил төлөвлөсөн тул гарын үсэг зурах боломжгүй ажээ.

БАГА ХҮЧ

Өөр нэг дохио бол зэвсэглэлээр төдийлөн


загварын онгоц 14 нэгж буюу нийт 27.2 тэрбум ам.долларын гэрээг хийсэн нь дэлхийн зэвсгийн зах зээл дээр "цөмийн бөмбөг" хаясантай адилхан үйл явдал болсон. Энэхүү гэрээ хамгийн том нь бас биш юм. Зарим эх сурвалжид бичигдэж байгаагаар Америкийн "B61-12" загварын цөмийн бөмбөг тээвэрлэгч онгоц нь Бельги, Итали, Нидерланд,

явуулсан бичигт дурдсан байна. Энэхүү бичигт "Магадгүй финчууд Ленинградын бүсэд байрлах бүх "Искандер-М" цогцолбор Балтын тэнгисийн орнууд руу болон тэдэн рүү харж байгааг мэдэхгүй байгаа байх" гэж бичжээ.

Бичгийн хариуд АНУ-ын Төрийн департамент болон Пентагоноос "Финландтай байгуулсан хэлэлцээрүүд нь бүс нутгийн цэргийн тэнцвэрт байдал аюул занал учруулахгүй" гэж мэдэгдсэн.

ЦӨМИЙН ЕРТӨНЦ

Сочи хотод болсон Аюулгүй байдлын асуудлаарх уулзалтын үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин "Стратегийн цөмийн шинэ хүчин" байгуулахаар болсноо мэдэгдсэн. Үүнээс гадна, "Цөмийн зэвсгийг хязгаарлах чиглэлээр төрөөс баримтлах бодлого"-ын үндэслэлийг батлах тухай зарлигт гарын үсэг зурсан. Тус зарлигт "ОХУ цөмийн зэвсгийг ашиглах тохиолдол нь "эцсийн бөгөөд албадлагын арга хэмжээ" гэж үзэх бөгөөд цэрэг дайны, түүний дотор цөмийн мөргөлдөөнийг өдөөж болзошгүй улс хоорондын харилцааг хурцатгахаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л хүчин чармайлтыг гаргах болно" гэж дурджээ. Энэ хурлын



Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путин: Яагаад америкчууд биднийг сонсохгүй байгаа юм бэ?

Герман, Турк дахь цэргийн баазуудад 200 орчим нэгж байдаг аж. Тус онгоцтой холбоотой сургалт, дадлагыг төрөл бүрийн хэлбэрээр явуулсаар байна. Үүнээс гадна, цөмийн зэвсэг эзэмшдэггүй ч Европын агаарын орон зайд чөлөөтэй нислэг үйлдэх боломжтой НАТО-ийн нисэх хүчин олон улсын гэрээг бүдүүлгээр зөрчих тохиолдол цөөнгүй гарчээ. Ийм үйлдлүүд нь цөмийн зэвсэг ашиглах, түүнийг хадгалах босгыг бууруулж, ОХУ-НАТО-ийн хооронд барьж байсан хил заагийг улам бүр хурцадмал байдал руу түлхэж, бусад улсын Европын холбооны орнуудад итгэх итгэлийг сулруулж байгааг ОХУ-ын Гадаад хэргийн яамнаас ХБНГУ-ын цэргийн атташэд

үеэр В.Путин "Пуужингийн довтолгооноос хамгаалах, цохилт өгөх системийг сансарт бий болгох, байрлуулах нь аюултай гэж үздэг бөгөөд саармагжуулахын тулд цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөх, түүнийг хориглох ажилд АНУ-тай илүү идэвхтэй байхыг уриалсан юм. Мөн цөмийн зэвсгээр аюулгүй байдлаа хангахаас илүүтэй олон улсад өөрсдийн байр суурийг хүлээн зөвшөөрүүлэх "шантааж" хэлбэрээр ашиглах болсныг онцолсон.

Эцэст нь хэлэхэд, Ник Картер, Чехийн Тагнуулын ажилтнуудын зөв гэж хэлье. "Бидний мэдэх дэлхийн аюулгүй байдлын талаарх ойлголт өөрчлөгдөж байна. Өнөөдөр дэлхийн аюулгүй байдал терроризмтой тэмцэх, коронавирусийн халдвараас сэргийлэх, пуужин, цөмийн технологийг дэлгэрүүлэхгүй байх, шилжих хөдөлгөөнийг хянах гэх мэт ердийн зүйлүүдээс бүрддэг болж. Дээрх асуудлуудыг даамжруулахгүй байж гэмээ нь шинэ "Берлиний хана"-ыг босгохгүй дэлхий ертөнц үнэхээр "хил хязгааргүй" хэвээр байх болно.

<https://tass.ru/opinions/9996703>
Орчуулсан ахмад Э.ОЧҮҮ



B-21

ЭРГЭН ДУРСАХУЙ ДОР СЭТГЭЛ ЦАЛГИНА

БХЭШХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан, терроризм судлаач, доктор (Ph.D), дэд профессор, бэлтгэл хурандаа С.ПҮРЭВДОРЖ

Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит, Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль нь 1921 онд Ардын цэргийн даргын сургууль нэртэйгээр байгуулагдаж, түүхэн шастираараа 100 жилтэй золгох гэж байна. Түүхийнхээ хугацаанд 30-аад мянган мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэн гаргасны дотор Монгол Улсын баатар, төр, цэрэг, нийгмийн зүтгэлтнүүд зэрэг олон арван алдартныг төрүүлсэн байна. ҮБХИС өнөөдөр Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, иргэний нийгэмд хүний нөөц бэлтгэх, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, иргэний салбарт суурь болон хавсарга судалгаа явуулдаг судалгаанд суурилсан их сургууль болж ажил үйлс нь өдрөөс өдөрт өнгөжин жавхааж байгаа билээ.

Хүмүүний хувь тавилан хүмүүжлээс, улсын хувь заяа байрлалаас гэдгийн адилаар хоёр том гүрний хооронд оршиж, гаднын гурав дахь шууд аюул заналаас ангид шахам байдаг ч улс орны хөгжил, аюулгүй байдал хоёр салшгүй холбоотойгоос Батлан хамгаалах салбарын чадавч, хөгжил дэвшил юу юунаас чухал байдаг. Тийм ч учраас цэрэг, эх оронч хүмүүжлийг хүүхэд, залуучуудад өсвөр бага насанд нь олгож байхын чухлыг онцолж, одоогоос 10 гаруй жилийн өмнө тухайн үеийн Батлан хамгаалахын сайд Л.Болд, БХИС-ийн захирал, бригадын генерал З.Болдбаатар нарт ОХУ-ын Суворовын сургуультай адил төстэй сургууль байгуулах чиглэл, зөвлөмжийг тухайн үеийн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаас өгсөн байдаг.

Тэгээд нэг их удалгүй "Тэмүжин Өрлөг" дунд сургуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлалгаар 2010 онд байгуулсан бөгөөд цэргийн анхан шатны боловсрол олгох төрөлжсөн сургалттай бүрэн дунд сургуулийг байгуулсан их түүхтэй билээ.

Түүхээ эргэн санахад, 1921 онд Ардын хувьсгал ялсны дараагаар 1925 онд ХХ зууны түүхэнд төрсөн цэргийн нэрт жанжин, Ардын Хатанбаатар С.Магсаржав Цэргийн ерөнхий сургуулийн дэргэд 14-16 насны хүүхдүүдээс бүрдсэн Цэргийн дунд сургууль байгуулах чиглэлийг анх гаргаж байжээ.

1943 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс Ерөнхий боловсролын сургуулийн 4-7 дугаар анги төгссөн хүүхдүүдээс сонгон авч, 1-3 дугаар курст суралцуулахаар шийдвэрлэж, 8 бүлэг, 234 сурагчтайгаар анх Офицерын сургууль бий болсон түүхтэй. Офицерын сургуулийг үүсгэн байгуулж, Цэргийн яаманд харьяалуулан тус сургуульд ерөнхий эрдмийн бүх хичээлийг үзэхээс гадна цэргийн хэргийн жагсаал, биеийн тамир, цэргийн дүрмүүд, зөвсгийн бие анги, буудлага, цэргийн газрын зураг, морин сургууль, тактик гэсэн найман төрлийн хичээлийг ордог байжээ. Бид Офицерын сургуулийн төгсөгч Төрийн соёрхолт, Ардын эмч Ж.Хайрулла, Батлан хамгаалахын сайд асан, дэслэгч генерал Л.Моломжамц, хошууч генерал С.Гомбосүрэн, хөдөлмөрийн баатар Г.Мандах, хошууч генерал О.Отгонжаргал зэрэг алдартнуудаар бахархах нь зүй эрэг.

Тэгвэл офицерын сургуулийн өнөөгийн залгамж халаа нь "Тэмүжин Өрлөг" бүрэн дунд сургууль юм. Тус сургууль нь 2010 онд дөрвөн багш, 30 сурагч-сонсогч, дөрвөн ажилтантайгаар тухайн үеийн Цэргийн инженерийн сургуулийн нэг давхрын баруун



хэсэгт гал голомтоо бадраасан түүхтэй болой. Тухайлбал, тус сургуулийн анхдагч болох захирал, бэлтгэл хурандаа С.Наранцогт, цэргийн албаны тасгийн дарга, дэд хурандаа Ж.Пүрэвсүрэн, багш Р.Энх-Амгалан, У.Тунгалаг-Оюун, Г.Наранчимэг, Б.Цэцэгмаа, С.Зинамидар, үйлчлэгч Г.Наранцацрал, Х.Цэцэгдулам нарын бүрэлдэхүүнтэй хамт олон бүрдэж, байр, тэнхимээ засварлаж тохижуулах, сурагчдаа хүлээн авах бэлтгэлийг хангах, багш нар хичээлийн бүх төрлийн бэлтгэлжилтийг хийж зохицуулах зэрэг олон талт ажлыг өрнүүлснээр буян хишиг нь дэлгэрэх их үйлсийн үүд нээгдсэн юм.

Эргэн дурсах мөчид-2013 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Нийслэлийн Засаг даргын захирамжаар Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэг, "Боловсролын тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Батлан хамгаалахын их сургуулийн дэргэдэх "Цэргийн лицей" (Нийслэлийн Засаг даргын 2011 оны 727 дугаар захирамж) бүрэн дунд сургуулийн нэрийг "Тэмүжин Өрлөг" бүрэн дунд сургууль гэж өөрчилсөн түүхтэй.

Эргэн санахад, тухайн үеийн цэргийн албаны тасгийн дарга, дэд хурандаа Ж.Пүрэвсүрэн, ахлах дэслэгч П.Үнэнбат нарын ажил, ачаалал асар их байсан бөгөөд цэргийн албаны асуудал, өдрийн цай, хооллолтын ажил, алслагдсан дүүргээс болон хөдөөгөөс ирсэн сурагчдыг байрлуулах,

сургалт бэлтгэлийг хийлгэх, БХИС-ийн дотоод журам, үйл ажиллагаатай тус сургуулийн ажил, үйлчилгээг уялдуулах асуудлаар олон удаа үүрэг, чиглэл, зөвлөмжийг өгч ажиллаж байснаа эргэн дурсахад, тус сургуулийн нийт бие бүрэлдэхүүн түүний дотор цэргийн албаны дарга маш сайн ажиллаж, өгсөн үүргийг цаг тухайд нь биелүүлэхэд онцгой анхаарч өдөр шөнийг ялгалгүй ажиллаж байсан даа.

"Тэмүжин Өрлөг" сургуулийн эрхэм зорилгыг нь "Монгол Улсын ирээдүйн хөгжилд манлайлан оролцох оюуны өндөр чадавхтай, бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй, хүмүүнлэг иргэнийг нийгэмд болон Зэвсэгт хүчинд бэлтгэх" гэж тодорхойлсон байдаг. Тухайлбал, цэргийн дунд сургуулийн сурагчид цэргийн дүрмийн дагуу дарга, найз нөхөдтэйгөө мэндэлж ёслох зэрэг тодорхой үүрэг хүлээн, сургуулийнхаа тангаргийг өргөдөг. Сурагчид тангаргатаа:

"Өвгөдөөс уламжилсан түүх, соёлоо дээдэлж Өөдлөх ирээдүйг цогцлоон бүтээх Өв тэгш иргэн болохоо Аав, ээж, ачит багш нарынхаа өмнө Анд найз, ангийн нөхдийнхөө өмнө Тангараглаж байна, тангараглаж байна, тангараглаж байна" хэмээн ёслол хүндэтгэлтэйгээр тангаргаа өргөж байсан юм.

Энэхүү тангарагтаа үнэнч байж, шударгаар биелүүлэх үүрэгтэйгээ ухамсарлан өсөж буй эдгээр хөвгүүд ирээдүйн генерал, офицерууд болох нь дамжиггүй юм. Ийм л омогшлоор хүүхэд цэргийн хүн болгох сонирхол монголчуудын дунд хэдийнээ бий болжээ.

Гэхдээ төлөвшиж тэлэгдээгүй ухааныг цэргийн дэглэмээр хэтэрхий хайрцаглаж болохгүй нь ойлгомжтой байсан юм. Тэд ирээдүйд хүний нөхөр, хүүхдийн аав болно. Цэргийн сургуульд бүхий л зүйл захиран тушаах хэлбэрээр явагддаг учраас хүүхдүүд хүний хий гэснийг хийдэг, өөрөө сэтгэхгүй байх вий гэдэгт онцгой анхаарал хандуулан цагийн хуваарь, сургалтынхаа хөтөлбөрийг нягт нямбай боловсруулсан байдаг. Тиймээс хүүхдүүдийг аль болох өөрийнхөө нь чөлөөтэй байлгаж, "дүрсгүйтэх"-ийг нь ч хорьдоггүй. Хүүхэд насыг нь хүндэтгэх нь хамгийн чухал болж байлаа. "Тэмүжин Өрлөг" сургуулийн хичээлийн

хүүхдүүдийн сэтгэлгээний хурд, бие бялдрын хөгжил, багш нарын заах арга зүй, чадвар дутахааргүй байсан юм.

Түүнчлэн хүүхдээ үг даадаг, сайхан сэтгэлтэй, эмх цэгц, сахилга баттай болгох зорилгоор цэргийн сургуульд оруулдаг байна. Ер нь сүүлийн жилүүдэд "Тэмүжин Өрлөг" сургуульд хүүхдээ сургах сонирхолтой ээж, аавын тоо эрс нэмэгджээ. Тус сургууль жилд 30 хүүхэд элсүүлдэг бол хот хөдөөгийн 400-500 хүүхэд өрсөлддөг нь үүний тод жишээ болж байлаа. Элсэлтийн шалгалтаа ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын амралт эхэлснээс хойш хоёр долоо хоногийн дараа явуулж байгаа нь бүх аймаг, хотоос суралцагчдад элсэн суралцах боломжийг олгох зорилготой юм.

"Тэмүжин Өрлөг" сургуульд бүтэн болон хагас өнчин, амьдралын боломж тааруу хүүхдүүдийг сурган, тэднийг бусдаас дутуу биш гэдгийг нь ойлгуулах, хүүхэд насаа баяр жаргалтай өнгөрөөхөд нь тусалж дэмжин, эх орондоо хэрэгтэй эр хүн болж төлөвшүүлэх гол зорилготой байсан. Тэд адилхан хоол идэн, ижилхэн хувцас өмсөж харагдах байдлаараа ч хэн нэгээс дутуу биш гэдгээ мэдэрч өснө. Тус сургуульд суралцаж буй хүүхдүүдийн 20 орчим хувь нь хагас болон бүтэн өнчин бол 40 орчим хувь нь амьжиргааны түвшин доогуур айлын хүүхдүүд ажээ. Гэхдээ энэхүү судалгааг хүүхдүүд сургуульдаа тэнцэж, элссэний дараа гаргадгаараа онцлогтой. Түүнээс биш "хаая" гэх малгүй, "хөө" гэхгүй хүнгүй хөвгүүдийг онцолж "Тэмүжин Өрлөг"-ийнхөн тухайн үед сонгоогүй. Гэхдээ энэ сургуульд дандаа борчуудын хүүхэд сурдаг гэж өрөөсгөл дүгнэлт хийж болохгүй юм. Төрийн өндөр албанд ажилладаг, тансаг амьдралтай хүний хүүхдүүд ч тэдний эгнээнд бий.

1989 онд батлагдсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 38 дугаар зүйлийн 2-т заасны дагуу 13-аас доош насны хүүхдэд цэргийн анхан шатны боловсролыг олгохыг хориглодог учраас 13 наснаас буюу долоо дугаар ангиас нь элсэлт авдаг болсон ажээ. Анхны элсэгчид маань 2016 онд сургуулиа төгссөн. Ерөнхий боловсролын сургуулийн зургаадугаар ангиа төгсөөд энэ сургуульд "данс"-тай болсон цагаасаа л тэд хүрэх зорилгоо олж хардаг талаар нэг биш удаа сургуулийн удирдлага, багш нарын хэлсэн үг, сэтгэлээс үргэлж уяатай явдаг юм. Ер нь сурагчидтай уулзан ярилцаж байхад ч тодорхой зорилготой

цагт цэрэг хүн зоригтой, тэвчээртэй, тууштай, энгийн үед шударга, тайван дөлгөөн, энэрэнгүй байхыг сурган аав, ээжийн захиас гэлтэй. Өнөө цагт бид бүхэн үр хүүхдэдээ эх оронч хүмүүжил, монгол бахархлыг төлөвшүүлэх зүй ёсны шаардлага гарч ирж байна.

Цэргийн сургуульд хүүхдээ сургах хүсэл м о н г о л ч у у д а а р х я з г а р л а г д с а н г ү й . Улаанбаатар хотод амьдарч, ажиллаж буй ОХУ-ын иргэдээс тус сургуульд хүүхдээ сургахаар цөөнгүй хүсэлтийг ирүүлж байлаа. Үүний зэрэгцээ охид хүртэл цэргийн сургуульд сурах хүсэлтээ ирүүлж байсан. Хүүхдийн сурах эрхийг хүндэтгэн охидыг сургах асуудлыг тухайн үеийн удирдлага нааштай шийдэх боломжтой анхаарч авч үзсэн байдаг. ОХУ-ын Цэргийн дунд сургуульд ч эмэгтэй сурагч олон суралцдаг бөгөөд Ангарск хотын Шүхэр десантын ангид суралцагчдын 25 хувь нь эмэгтэй хүүхэд байдаг ажээ.

Тиймээс "Тэмүжин Өрлөг" бүрэн дунд сургууль ч хүрээгээ тэлж, хараагаа өргөсгөнө гэдэг нь ойлгомжтой.

Монгол Улсын Зэвсэгт хүчний ирээдүйн залгамж халаа энэ сургуульд бэлтгэгдэж байна. "Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа" гэдэг. Тэр дундаа цэргийн хүн, цэргийн хүмүүжлийг багаас олгох нь тэднийг эх орноо хайрлах сэтгэлийг нь цуг төлөвшүүлж байгаа хэрэг. Сүр жавхлан, цог хийморьтой Зэвсэгт хүчний хойч үеийг бэлтгэх их үйл хэрэг ийнхүү үргэлжилж үр дүнгээ өгч байна.

Эргэн дурсахад, Батлан хамгаалахын их сургуулийн хашаанд 2015 онд "Тэмүжин-Өрлөг" сургуулийн шинэ гурван давхар байрыг ашиглалтад оруулсан нь цаашдын сургуулийн хөгжил дэвшилд онцгой үр дүнгээ өгч байна. Байрныхаа нэгдүгээр давхарт захирал, багш, ажилчдын өрөө, хооллох танхимтай. Ирээдүйн генерал, офицер"-ууд маань хоёрдугаар давхартаа хичээллэж, гуравдугаар давхарт нь Улаанбаатар хотын ажиллагдсан дүүрэг, хөдөөгөөс суралцагчид амьдардаг ажээ. Өнөөгийн байдлаар 50 гаруй багш, ажилтан, 13-18 насны 350 гаруй суралцагчтай. Сурагчид нь Даваа гарагаас Баасан гараг хүртэл сургууль дээрээ байрлаж, амралтын өдрөөр гэртээ харьдаг цагийн хуваарьт бүрэн шилжсэн ба үйл ажиллагаа нь тогтмолгоод байна.

Эх оронч үзэл бол монгол хүн бүрт байх ёс суртахуун, хүмүүжил байх учиртай. Манай "Тэмүжин Өрлөг" сургуулийн хамт олон сурагчдаа бие бялдар, гоо зүйн болоод эх оронч хүмүүжил буюу монгол бахархлыг олгож төлөвшүүлэхийн төлөө олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа билээ. Харин тэдгээр хүүхдүүд цэргийн хүн болох зорилготой, эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах тусгай мэргэжилтэй болно гэдгээ ухаарсан байгаа нь хамгийн том дэвшил, амжилт, бахархал болж байна.

Эргэн санахад, Агуу их Эх орны дайны ялалтын баярын үеэр ОХУ-ын Ангарск хотноо болсон Ялалтын баярын жагсаалд БХИС-ийн "Тэмүжин Өрлөг" сургуулийн сурагчид оролцсон нь онцгой үйл явдал байсан юм.

Мөн "Монгол цэргийн жавхаа-2015" уралдааны үеэр тус сургуулийн сурагчид Цэргийн сургуулийн сурагчдын дүрэмт хувцсаар жигдэрч, бөмбөрийн дуунаар жанжин Д.Сүхбаатарын талбайн төв хэсэгт үзүүлэх тоглолтыг үзүүлснээр цэргийн албаны эмх цэгц, үр чадварыг гайхуулан олны хайрыг татахын сацуу үүнийг тэрлэгч миний бахархлыг минь төрүүлж, сэтгэл минь цалгиж байсныг удирдаж, зохион байгуулж явсан хүнийхээ хувьд дурсан санахуй дор энэхүү нийтлэлээ энэ удаад жаргаамуй.



аюулгүй ажиллагааны асуудлыг нь зохицуулах чиглэлээр БХИС-ийн Захиргаа зохион байгуулалт эрхэлсэн тэргүүн дэд захирлын хувьд нэлээд хэдэн жил хамтран ажилласан юм.


Эхний ээлжинд цагийн хуваарьт ажиллагааг хэвшүүлж мөрдүүлэхээс эхлээд дүрэмт хувцас болон тусгай хувцас хэрэглэлийг өмсөж хэвшүүлэх, цэргийн хэргийн анхан шатны

хөтөлбөрийг ОХУ-ын Суворовын сургуулийн сургалтын хөтөлбөртэй харьцуулж үзэхэд, сургалтын чанар, үр өгөөж нь тэднийхээс хоцроогүй, зарим нэг талаараа илүү үр дүнд хүрэхүйц боловсруулагдсан байх жишээтэй.

Харин бусад орны цэргийн дунд сургуультай харьцуулахад материаллаг баазын хувьд гэхээс биш

болсноо бахархан хэлж байсан юм. Тус сургуулийн хоёрдахь захирал асан доктор (Ph.D), профессор, дэд хурандаа В.Дашпунцаг "Айл зуур явахад алаг бярүү шиг номхон, Алалдах дайсан ирвэл арслан бар шиг догшин бай" гэж эцэг өвгөдөөс сургасан талаар хүүхдүүдэд хандан хэлж байсан нь тод санагдана.

Энэ нь эх орон дуудсан



Дугаарын зочин

Өнөөгийн нийгэмд хүн бүр стресс, уур бухимдал, элдэв өвчлөлд өртөмтгий болсон. Эдгээрийн дийлэнх нь хүн амын нягтаршил, завгүй нэг хэвийн амьдрал, хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй. Үүнээс сэргийлэх, эрүүл мэнддээ анхаарал тавихыг хүсэж буй хүн бүрийн сонголтот тааруулан олон төрлийн үйлчилгээ бий болж байгаа нь сайшаалтай. Тухайлбал, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх спиннинг, фитнес, иог зэргийг нэрлэж болно. Эдгээрээс хүний биед сэтгэл санаа, дотоод заслыг хамтад нь бүрдүүлж чаддаг нь иог аж. Тиймээс бид иогийн давуу тал, ач тусын талаар "Асури повер" иогийн төвийг зорьж багш Д.АЗЖАРГАЛТАЙ ярилцлаа.



Д.Азжаргал: ИОГИЙГ АМЬДРАЛЫНХАА НЭГ ХЭМНЭЛ БОЛГОЖ ЧАДВАЛ ЭМНЭЛЭГ ЯВАХ ШААРДЛАГА ГҮЙ

Иог гэж юу вэ?

-Иог нь дотроо олон төрөлтэй. Хүмүүсийн дунд иогийг зөвхөн эмэгтэйчүүд хийдэг гэсэн ойлголт элбэг байдаг. Энэтхэгт хамгийн анх иогийг эрэгтэй хүн үүсгэж байсан түүхтэй. Иог гэдгийг зарим хүмүүс их хүндээр тусгаж авдаг. Хүнд хэлбэрийн дасгал, хөдөлгөөн хийх нь иог юм байна гэж ойлгодог энэ бодлоосоо үүдэн шантардаг. Иог нь зүгээр л өөрийгөө эрүүл байлгах энгийн нэгэн дасгал гэдгийг ойлгохивол хичээллэж эхлэх гэж буй хүнд төдий чинээ амар. Иогийн дасгал хүнээс уян хатан хөдөлгөөн, тэвчээр хатуужлыг ихээр шаарддаг ч заавал уян хатан байх ёстой гэж ойлгож болохгүй. Учир нь иог өөрөө хүнийг уян хатан болгодог юм. Ер нь иогийн дасгалыг шууд өндөр ачаалал авахгүйгээр бага багаар өөрийгөө дасгаж хийх нь чухал. Хэрэв хүн иогийг амьдралынхаа нэг хэсэг, хэмнэл болгож чадвал эмнэлэг явах шаардлага гарахгүй. Учир нь иогийн дасгал, хөдөлгөөн нь хүний гадна, дотор бүх эд эс, булчин, шөрмөст хүрч тэдгээрийг эрүүлжүүлэх, дархлаажуулах үндэстэй байдаг. Мөн иогт дурласан хүмүүсийн ихэнх нь ямар нэг асуудлаас болж иогийн төвийг зорихоосоо өмнө эмнэлгийг зорьсон байх нь элбэг.

Иогийн төрлүүдийн тухайд ...

-Энэтхэгийн иогийн үндэс бол Хатха иог юм. Он жил өнгөрөх тусам хатха иог дээр үндэслэн иогийн олон төрлүүд бий болсон. Тухайлбал, Хатха иог, Айенгар иог, Аштанга иог, Виньяса иог, Бикрам иог, Халуун иог, Бихар иог,

Кундалини иог, Агаарын иог, Повер иог зэрэг.

Эдгээрээс манай улсад аль иог нь эрчимтэй хөгжсөн байдаг вэ?

-Энгийн буюу Хатха иог нь хамгийн түгээмэл. Мөн агаарын иог хүч түрэн орж ирж байна. Тэгээд Халуун иог болон Повер иогийн төрлүүд цөөн тоогоор үйл ажиллагаагаа явуулдаг. Энд нэг зүйлийг нэмж хэлэхэд, хүний нас, биеийн онцлогоос шалтгаалан ямар төрлийг сонгон хичээллэх нь өөр өөр байх хэдий ч иог гэсэн ерөнхий ойлголтоороо хүн бүрд чухал гэдгийг анхаарах хэрэгтэй.

Та ямар төрлийн иогийг заадаг вэ?

-Миний хувьд Повер иогийн багшаар ажилладаг. Манай Повер иог Монголдоо цор ганц гэдгээрээ онцлог.

Повер иог нь бусад иогоос юугаараа онцлог давуу талтай вэ?

-Түргэн хугацаанд үр дүнгээ өгдөг. Хамгийн гол нь галбиржих, эрүүлжих, уян хатан болох зэрэг үйл явц биед цогцоороо бий болдог онцлогтой. Булчинг зэрэг дэмжих, булчин руу чиглэсэн дасгалууд ерөнхийлж ордог. Нэг бүрчлэн нэрлээд байвал маш олон давуу тал бий. Насан туршдаа нурууны өвчингүй амьдрах арга зам бол иогоор, тэр дундаа Повер иогоор хичээллэх гэдгийг хэлмээр байна. Яагаад гэвэл, хүн иогийн дасгал хийх үед биеийн баруун, зүүн талд хоёуланд нь яг ижилхэн тэнцвэртэй ачаалал өгч, булчинг хөгжүүлж бас суллаж чаддаг. Хамгийн том ач тус бол турна, галбиржина, эрүүлжинэ, залуужина, стрессээс ангижруулах зэрэг ач

холбогдолтой.

Та сая залуужуулна гэлээ, энэ тухайгаа тодорхой тайлбарлана уу?

-Шөрмөсний сунгалт нь хүнийг залуужуулдаг. Иог хийгээд сунгалт сайжраад байхаар шөрмөснөөс гарч байгаа хөлс хүнийг дотроос нь тэжээдэг. Повер иогийн дасгалууд дунд залуужуулах дасгал ч ордог.

Дийлэнх хүмүүс асар богинохон хугацаанд хүссэн үр дүнгээ харах хүсэлтэй байдаг. Повер иогоор хичээллэснээр хэр хурдан хугацаанд үр дүнгээ өгч эхлэх вэ?

-Эхний өдрөөс л эхлэн үр дүнгээ өгч эхэлнэ. Эхний өдөр бие булардаг. Хүний биед хуримтлагдсан хортой хийнүүд маш сайн гадагшилна. Хэрүүлэх, унгах, савны хий гарах гэх мэт шинж тэмдэг илэрдэг.

Иогийн үед хоолны дэглэм барьдаг уу? Жишээ нь бусад тураах газрууд гурил, будаа гэх мэт бүтээгдэхүүнийг идэж болохгүй гэдэг шиг хориглох хоолны заалт байдаг уу?

-Иогийн үеэр хоолны дэглэм барьдаггүй. Яагаад гэвэл эрчимтэй булчинд чиглэсэн дасгалууд голлодог учир уураглаг хоолноос гадна хүссэн хоолоо иддэгээрээ бусад иогоос ялгарах нэг давуу тал болно. Гэхдээ дасгалын хугацаанд чихэрлэг зүйл, газтай ундаа гэх мэт цусан дахь холестеринийг нэмэгдүүлэх зарим цөөн хүнсийг түр хорих хэрэгтэй. Үүнийг хэрэглэхгүй 10-20 хоноод ирэхээрээ хүний бие цаанаасаа нэхэх дуршил нь алга болчихдог.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

ГЭРЭЛ ЗУРАГ-НЭГ АГШИН



Тэнгэр нь цэлмэг, газар нь зөөлөн байг. Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

ОНЧ ҮГ

Амжилт үйл олон алдаагаар хуьндсан байдаг

Бернард Шоу

ЭМГЭНЭЛ

ДОРЖСҮРЭНГИЙН ХИШИГБАЯР (1964-2020)

Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгын дуучин, алдарт "Жаран хар"-ын жагсаалын содон хоолой, Соёлын тэргүүний ажилтан Доржсүрэнгийн Хишигбаяр өвчний учир таалал төгсч, Монголын урлагт нөхөж баршгүй гарз тохиолоо.

Дуучин Д.Хишигбаяр нь 1964 онд Улаанбаатар хотод мэндэлсэн. 1980 онд Нийслэлийн 62 дугаар дунд сургууль, 1982 онд Багшийн сургуулийг тус тус дүүргэсэн.

1982-2011 онд Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгад Дуучнаар, 2011-2015 онд Цагдаагийн "Сүлд" чуулгад менежер, 2015 оноос Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгад менежер, жижүүрээр ажиллаж байлаа.

Д.Хишигбаяр нь тус чуулгад 30 гаруй жил ажиллахдаа дагалдан дуучнаас найрал дуучин, гоцлол дуучин, найрал дууны ангийн группын дарга хүртэлх албан тушаалуудад дэвшин ажиллаж байлаа. Тэр бээр төрийн хүндэтгэлийн болон баярын концерт, гадаад, дотоодын зочдоод зориулсан 4000 гаруй тоглолтод оролцож, 500 гаруй найрал дуу, түүний дотор 60 гаруй дууг гоцлол дуулсан авьяаслаг нэгэн байлаа.

Тэрээр Урлагийн гавьяат зүтгэлтэн Р.Ганбатын "Насны ганцхан хань", "Миний багын Дууяа", Ардын жүжигчин Н.Жанцанноровын "Ганцхан чи минь", Д.Гун-Аажавын "Цэнхэр хангайн нутаг", Ардын жүжигчин П.Хаянхярваагийн "Хонгор нутгийн түмэндээ", СТА Ж.Даваагийн "Үүрийн шөнийн нулимс", Б.Бадарчийн "Сартай шөнийн уянга", гавьяат жүжигчин Н.Чулуунхүүгийн "Ээж таныгаа үгүйлнэм зээ", "Ханийн тэнгэр", "Халагдах цэргийн вальс" дуунуудыг дуулж, сонсогч, үзэгчдээс өндөр үнэлэлт авсны зэрэгцээ 20 гаруй дуугаа МҮОНРТ-ийн алтан фондод мөнхжүүлэн 5 удаа уран бүтээлийн бие даасан тоглолтоо хийжээ.

1986 онд Соёлын яамны "Шилдэг уран бүтээл"-ийн шагнал, 1988 онд "Морин хуур" хөгжмийн наадам, 1990 онд "Цагаан лавайн эгшиг" шилдэг дууны наадмын тэргүүн шагнал, 1991 онд Эзэнтэй дууны улсын уралдаанд дэд байрын шагнал, 1991, 1992 оны "Морин хуур" наадмын Үзэгчдийн нэрэмжит шагнал, 1994 онд МУЗН-ийн "Энэрэхүйн үйлс" улсын уралдааны тэргүүн шагнал, 1996 онд "Монгол адуу" морины дуу дуулаачдын улсын уралдааны дэд байрын шагналыг тус тус хүртэж, дуулаачийн уран чадвараа илтгэн харуулсан авьяаслаг уран бүтээлч билээ.

Тэрээр ЦДБЭЧ-ын ОХУ, БНХАУ, БНАСАУ, Унгар, Чех, Польш зэрэг орнуудаар хийсэн айлчлан тоглолтын бүрэлдэхүүнд оролцож, өөрийн эх орны урлаг, соёлыг дэлхий дахинд сурталчлах үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулсан байна.

Түүний гавьяа, зүтгэлийг төр, засгаас өндрөөр үнэлэн Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль, улс, армийн ойн медалиуд, "Дайчин алдар-I, II, III", "Дайчин нөхөрлөл", БХЯ-ны 100 жилийн ойн медаль, ХХЕГ-ын хүндэт тэмдэг, Монголын "Цагдаагийн гавьяа" хүндэт тэмдэг, МХЗЭ-ийн Төв хорооны "Цэргийн алдар" алтан медаль, "Тэргүүний сэхээтэн залуу" алтан медаль, "Хөдөлмөрийн алдар" алтан медаль, Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Хүндэт иргэн" цол, тэмдгээр тус тус шагнажээ.

Таны минь шавхагдашгүй авьяас билэг, уянга яруу дуу хоолой, хүнлэг нинжин сэтгэл бидний зүрхэнд үүрд дурсагдах болно.

Гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсдөд нь гүн эмгэнэл илэрхийлье.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ, ЦДБЭЧ-ЫН УДИРДЛАГА, ХАМТ ОЛОН

Эрүүл мэнд

КОВИД-19 ӨВЧНИЙ ХОЁР ДАХЬ ДАВЛАГААНААС ИРГЭД БИД ӨӨРСДИЙГӨӨ ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?

- АХУЙН АРИУН ЦЭВРИЙГ ЧАНД САХИХ
- МАСК ЗҮҮХ
- ГАРАА ТОГТМОЛ УГААХ
- ОЛОН НИЙТИЙН ГАЗРААР БАГА ЗОРЧИХ
- ИЛ ЗАДГАЙ НУС ШҮҮСЭЭ ХАЯХГҮЙ БАЙХ
- ГАР УТАС ГЭХ МЭТ ЭД ЗҮЙЛСЭЭ ТОГТМОЛ ЦЭВЭРЛЭХ



СОЁМБО СОНИН

"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна. Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонины редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламг хямд нийтэлнэ.
*Зар, рекламг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018

И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029

ОНЦЛОХ ЭРХЭМ

Эрхэм хурандааг олон өнцгөөс нь мэдэх юм. Цэргийн алба хаагч, хүний сайн хань, хүүхдүүдийнхээ бахархалт аав, сайн дүү, итгэлт нөхөр гээд олон илэрхийлэл гарах байх. Гэхдээ хэдий хичээл заалгаж үзээгүй ч “Мийгаа багш” гэж дуудан хэзээ ч, хаана ч таарсан хөгжилтэй, тусч зангаа дэлгэж, байгаагаараа байдаг гэж ам бардам хэлж чадна. Ярилцлага авах гэж олон удаа санал тавьж “Ах нь юугаа ярих вэ” гэсэн татгалзсан хариулт авсны эцэст алс хол Америк улсад байхад нь холбогдон ярилцах завшаан тохиосноо уншигч тантай хуваалцъя.

Амрыг эрье. Ажил, алба тань сайн биз дээ. Ярилцахыг зөвшөөрсөнд баяртай байна. Уншигчдад маань өөрийгөө дэлгэрэнгүй танилцуулснаар ярилцлагаа эхэлье. Нутаг ус, аав, ээж, төгссөн сургууль гээд ...

-Амрыг эрье. Танай сонины эрхэм уншигчдад мэнд хүргэе. Би Өвөрхангай аймгийн Арвайхээр хотынх. Хуучнаар Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошуу, одоогийн Өвөрхангай аймгийн Сант сумын Цэриг багийн уугуул. Өвөрхангайн цэргийн анги буюу Их-Уулд бага насны минь ихэнх хугацаа өнгөрсөн дөө. 1995 онд Их-Уулын 10 жилийн дунд сургууль, 2001 онд БХИС-ийг инженерийн командын офицер, зам гүүрийн машин механизмын инженер мэргэжлээр төгссөн. Мөн АНУ-д Инженерийн офицерын үндсэн дамжааг 2001 онд, Англи хэлний багшийн үндсэн дамжааг 2003 онд, АНУ-ын Тэнгисийн цэргийн төгсөлтийн дараах сургуулийг Стратеги судлал, аюулгүй байдал судлалын магистрээр 2016 онд тус тус төгссөн. Магистрт суралцаж байхдаа АНУ-ын Тэнгисийн явган цэргийн Команд штабын коллежийг зайны сургалтаар суралцаж дүүргэсэн. Эх орныхоо төлөө хэрэгтэй цагт амиа өргөх тангарагтай жирийн л нэгэн цэрэг хүн. Ах дүү олуулаа. Нэг эгч, хоёр ах, зургаан дүүтэй. Би өөрөө одонгийн хүүхэд. Эгч маань Чех улсад хүүхдүүдтэйгээ ажиллаж, амьдарч байна. Ах, дүү нар маань ихэнх нь Улаанбаатар хотод барилгын салбарт сантехникч, цахилгааны инженер, засал чимэглэлчин, цахилгаанчин зэрэг мэргэжлээр ажиллаж байна. Хөтөлийн цемент шохойн үйлдвэрт зарим дүү нар маань инженер, ээлжийн ахлагчаар ажиллаж байна. Дандаа л бүтээн байгуулалтын салбарт ажилладаг.

хэмээх эрхэм нэгэн “чимэг”-тэйдээ баярлаж, бахархаж явдаг юм.

Багш хүний хувьд ямар зарчим баримталдаг вэ? Таныг их хатуу багш гэж цөөнгүй хүнээс сонсож байсан ...

-Би “хатуу” багш биш ээ, нэлээд зөөлөн талдаа шүү. 2002 онд Зэвсэгт хүчний 150 дугаар ангид инженерийн сургагч багшаар томилогдохдоо үнэндээ эмээж байлаа. Хурандаа Дамба, дэд хурандаа Баасансүрэн гэдэг инженерийн шилдэг офицеруудаар сургагдсан мэргэжлийн офицер, ахлагч нарт сургууль төгсөөд удаагүй дэслэгч юугаа заана даа гэж халширч байсан. Гэхдээ тухайн үеийн удирдлага, сургагч багш нар, элитийн батальоны бие бүрэлдэхүүн их сайхан хүлээн авч, урам зориг хайрласан даа. Энэ ангид алба хаасандаа одоо ч бахархаж явдаг, маш их зүйлийг энэ л хамт олноос сурсан. 2003 онд АНУ-ын Батлан хамгаалахын хэлний хүрээлэн (DLI)-д англи хэлний багшийн дамжаанд суралцсан. Эргэж ирээд ангидаа англи хэлний хичээл зааж байлаа. Удалгүй Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын төвд ахлах багшаар томилогдсон юм. Тухайн үед цэргийн алба хаагчдад жаахан хатуу, хүндхэн нөхцөл өгчихвөл гарах үр дүн нь арай өөр байх шиг санагдсан. Өглөө цагийг нь яс бүртгээд гэрийн даалгавраа дэвтэртээ бичиж хийгээгүй бол, бие даалтаа хугацаандаа шалгуулаагүй, 17.55 ангидаа ороход байхгүй байвал “тас” тавьдаг байсан. Гайгүй үр дүн гарсан шүү. Нэлээд олон офицер, ахлагч гадаадад сургалтад явах шалгалтад тэнцсэн. Гэхдээ энэ бол үргэлж ийм байна гэсэн үг биш л дээ. Заах арга барилд сургагдаагүй муухар хүний л арга байх. Тухайн хувь хүн аливаа зүйлийг



Д.Мязмаржав: БАГШ ХЭМЭЭХ ЭРХЭМ НЭГЭН “ЧИМЭГ”-ТЭЙДЭЭ БАЯРЛАЖ, БАХАРХАЖ ЯВДАГ

Таны аавыг цэргийн хүн байсан гэж сонссон. Тэгэхээр таны сонгох мэргэжил тодорхой байсан байх. Тийм үү?

-Миний өвөө Н.Авирмэд Халхын голын дайнд 6 дугаар морьт дивизийн 17 дугаар морьт хорооны салааны туслах албан тушаалтай Дандар баатрын удирдлагад цэргийн алба хаасан ахмад дайчин байлаа. Миний аав А.Дорж Барилгын цэрэгт байлдагчаас хошууч болтлоо алба хаагаад 1990 онд тэтгэвэртээ гарсан. Эх орныхоо бүтээн байгуулалтад залуу нас, хөдөлмөр зүтгэл, мэдлэг, чадвараа харамгүй зориулсан. Өдгөө 77 настай, Хөтөл хотод амьдарч байна. Би эмээ, өвөөгийнхөө халамжид өсөж, тэр хоёрыгоо бурхан болсноос хойш эгч А.Оюун, түүний хань П.Мэндбаяр хоёрынхоо “гараар” хүмүүжсэн хүн дээ. Хүргэн ах маань ЦНДС-ийг төгсөөд 167 дугаар ангид холбооны салааны даргаар томилогдож ирээд эгчтэй минь танилцан гэр бүл болсон юм. Харамсалтай нь ах маань биднийг эрт орхиод тэнгэрт дэвшсэн. Миний эгч одоо Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн эмчээр ажиллаж байна. Зэвсэгт хүчний 256, 326 дугаар ангиудад цэргийн эмчээр ажиллаж байсан. Аав, хүргэн ах, эгч маань цэргийнхэн учраас надад сонголт хийхэд шууд нөлөөлсөн байх. Багаасаа л цэргийн хүн болохыг мөрөөдөж, хүсэлдээ хөтлөгдсөн.

Та багш, дарга, найз, хурандаа гээд олон янзаар дуудуулдаг байх. Гэхдээ багш аа гэж олон хүн хүндэтгэн дууддаг гэж боддог Танд ямар мэдрэмж төрдөг вэ?

-2001 онд сургуулиа төгсөөд Зэвсэгт хүчний 234 дүгээр ангид ротын захирагчийн техникийн орлогчоор томилогдож байлаа. Энэ ангид алба хааж байхдаа АНУ-д Инженерийн офицерын үндсэн дамжаанд суралцах зашаан тохиож энэ дамжааг 2002 онд төгсөж ирээд Зэвсэгт хүчний 150 дугаар ангид инженерийн сургагч багшаар томилогдсон юм. Тэр цагаас хойш “багш” хэмээх эрхэм хүндтэй алдраар дуудуулах болж, энэ их нэр төрийг дааж явахыг хичээж явна даа. 2002-2006 онд Зэвсэгт хүчний 150 дугаар ангид сургагч багш, 2006-2009 онд Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын төвд ахлах багш, 2009-2014 онд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвд ахлах багш, бүлгийн даргаар ажиллан 12 жил “багш” хэмээх буянтай мэргэжлийн эзэн болж, “багш аа” гэх дотно сайхан үгийг өөрийн нэртэйгээ хоршуулан дуудуулж явна. Багш хүн зааж сургахаас гадна зөвлөнө, өөрийн мэдлэгээ хуваалцана, хаанаас ямар мэдлэг, мэдээлэл олж авах вэ гэдгийг чиглүүлдэг. Олон хүний амьдралд шууд болон шууд бусаар нөлөөлдөг учраас өргөн мэдлэг, олон талын ур чадвар шаардсан мэргэжил гэж боддог. Эрхэмлэн дээдлэх сайхан мэргэжил. Цэргийн бусад алба хаагчдын нэгэн адил дарга аа, хурандаа гэж дуудуулдаг ч багш

сурахдаа, ялангуяа гадаад хэлийг сурахдаа өөртөө таарсан арга барилаа л олж авах нь чухал. Аливаа зүйлийг сурч мэдэхэд суралцагчаас маш их хичээл, зүтгэл гол нь сэтгэл гарах ёстой. Тэр л миний зарчим юм даа. Тиймээс л жаахан шахсан байх. “Энхийн цагт хөлс их гарвал, дайны цагт цус бага урсана” гэж үг байдаг. Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийн сургалт бол бүр ойлгомжтой. Ажиллагааны газар оронд үүсэж болох нөхцөлийг аль болох бүрдүүлж, нэлээд шахуу, хүндхэн нөхцөлд хэрхэн ажиллах вэ гэдэг арга ажиллагаанд сургагдаж бэлтгэгддэг онцлогтой. Аль болох л хүнд нөхцөлд сургагдчихвал ажиллагааны газар оронд очоод дороо л бүгд жигдрээд түрээхгүй хөнгөхөн л үүргээ гүйцэтгэнэ. Олон энхийг сахиулагчдынхаа бэлтгэлийг нь хангаж харь орныг зорин нисэхэд нь “Үүргээ сайн гүйцэтгэдэг эсэн мэнд ирээсэй” гэж дотроо залбирч үздэг. Тэднийгээ эргээд ирэхэд нь, “Үүргээ амжилттай биелүүлээ” гэж илтгэл өгч байгаа захирагчийг хараад “Бид ч бас үүргээ амжилттай гүйцэтгэлээ дээ. Нойр хоол, ар гэрээ умартан явсан ажлын минь үр дүн” гэж бодохоор үнэхээр бахархмаар сайхан байдаг.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа жилээс жилд өргөжиж монгол цэргийн нэр хүнд өндөр байгаа талаар таны бодол ... Танд хэрхэн мэдрэгддэг вэ?

-2002 оноос Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлснээс хойш Батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагаанд цоо шинэ хуудас эргэж жил ирэх бүр улам баяжин цэргийнхэн маань түүчээлэн хөгжүүлж байна. Гаднын улсад очиж үүрэг гүйцэтгэх, хурал зөвлөгөөн, уулзалтад оролцох гээд ер нь хаана ч гэсэн “Монгол цэргүүд үүргээ нэр төртэй гүйцэтгэдэг, Монгол цэргүүд биднийг хамгаалж байгаа болохоор бид амар тайван амардаг” гэж хэлэх бүрд үнэхээр бахархам сайхан байдаг шүү. Зөндөө л олон жишээ байна даа. Тухайлбал, миний хариуцсан ажиллаж байсан ТАБНУ-д явагдаж буй энхийг сахиулах ажиллагаанд рот оролцуулах тухай уулзалтыг зохион байгуулж, ажлын хэргийнхэн бид НҮБ-ын Энхийг ажиллагааны газрын дарга, тус газрын цэргийн зөвлөх нарт тодорхой саналаа танилцуулсан юм. Тэгэхэд НҮБ-ын Энхийн ажиллагааны газрын цэргийн зөвлөх, дэслэгч генерал Карлос Лойтэй Монголоос энэ чиглэлээр салбар оролцуулах боломжтой эсэх талаар санал авсан уу гэдгийг лавлаж, Монголоос салбар оролцвол өгсөн үүргийг ягштал биелүүлж чадна гэж онцлон хэлэхэд бас л гайхалтай мэдрэмж төрж байсан шүү. Өөрөө магтуулж байгаа юм шиг л сайхан.

Монгол хүн тэр тусмаа Монголын цэргийн алба хаагчид бид юугаараа илүүрхэж бахархах ёстой вэ?

-Бид их түүх, өвөг дээдсээрээ, уламжлал зан заншлаараа бахархаж, бидний цусанд Монгол нутгийн минь цаг агаар мөн ясны цэрэг байх тэр нэгэн хүчин зүйл мөнхөд оршиж байгаа гэж боддог. Уламжлагдаж ирсэн сахилга, зохион байгуулалт, захирах, захирагдах ёсыг ягштал биелүүлж, хариуцлагатай ажиллаж сурсан өөр нэг сайн чанар бас нөлөөлж байгаа. Энэ чанараа огт алдаж болохгүй. Одоо бид нэгэнт “Монголчууд үүргээ сайн гүйцэтгэдэг” гэсэн нэр хүнд, хариуцлагыг олж авсан юм чинь түүнийгээ улам чанаржуулах хэрэгтэй. Мэдээж зэвсэглэл, техник гээд асуудлууд байгаа. Түүнээс гадна сахилга бат, зохион байгуулалт, шат дараалсан удирдлага зэргийг улам боловсронгуй болгож удирдах албан тушаалтнуудынхаа мэдлэг, ур чадварыг байнга төгөлдөржүүлэн нийт алба хаагчдынхаа ур чадвар, үүрэг гүйцэтгэлийг улам сайжруулах чиглэлд анхаарч байвал энхийг сахиулах ажиллагааны хувьд бид улам л нэр хүндтэй болно. Одоо алба хаагчдынхаа мэдлэг, ур чадварыг улам дээшлүүлэх нь зөв юм болов уу. НҮБ-ын зүгээс ч цаашдын чиг хандлагыг харахад маневрлаг, орчин үеийн зэвсэглэл, техник, технологитой, ямар ч нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадвартай, мэдлэг, ур чадвар сайтай энхийг сахиулагчидтай байхыг зорьж, ийм шаардлагыг цэрэг илгээгч улс орнуудад тавьж байна. Энэхүү шаардлагуудыг хангаснаар энхийг сахиулагчид маань үүргээ амжилттай биелүүлэн эх орныхоо нэр хүндийг олон улсын тавцанд өргөх, цаашлаад НҮБ-ын гишүүн орны хувьд Монгол Улсын дэлхий дахины аюулгүй байдлын хангахад оруулж буй хувь нэмрийг улам тог томруун харуулах болно гэж боддог.

Одоо хашиж байгаа албан тушаалынхаа талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу? Энэ чиглэлээр ажиллах зорилготой хүмүүст хэрэгтэй мэдээлэл болох болно уу.

-НҮБ-ын Энхийн ажиллагааны газрын Цэргийн асуудал эрхэлсэн газарт Энхийг сахиулах ажиллагаа хариуцсан офицероор үүрэг гүйцэтгэж байна. Анх Цэргийн ажиллагааны хэлтсийн ТӨБНУ-д явагдаж буй “MINUSCA” ажиллагааг хариуцсан офицероор үүрэг гүйцэтгэж эхэлсэн ба 2020 оны 4 дүгээр сараас Цэргийн үүрэг гүйцэтгэлтийн үнэлгээний багт давхар томилогдон үүрэг гүйцэтгэсэн. Хоёр нэгжийн хоёулынх нь ажлыг хийнэ гэсэн үг. 10 дугаар сарын 5-ны өдрөөс үнэлгээний багт бүрмөсөн шилжиж “MINUSCA” ажиллагааг хариуцсан офицерын үүрэгт ажлаа хүлээлгэн өгөөд байна. Цэргийн үүрэг гүйцэтгэлтийн үнэлгээний баг нь цэргийн асуудал эрхэлсэн албаны орон тооны бус нэгж байсан тул бусад нэгжээс нийт 4 офицерыг энэ нэгжид давхар үүрэг гүйцэтгүүлж байсан ба он гараад албан ёсны нэгж болж батлагдсан. Тиймээс ажил үүргийн хувьд шинэ

бөгөөд их хариуцлагатай үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж эхэлж байгаа. Цэргийн хүчний штаб болон секторын штабаас зохион байгуулсан цэргийн багуудын үүрэг гүйцэтгэлтэд хийсэн дүн шинжилгээг нягталж, шаардлагатай мэдээллээр удирдлагыг хангах, үүрэг гүйцэтгэлт хангалтгүй байгаа цэргийн багуудын үйл ажиллагаанд дахин үнэлгээ, дүгнэлт хийх санал гаргах, тухайн цэрэг илгээгч улсад дүн, цаашдын арга хэмжээний талаар мэдээлэл хүргэх, тухайн цэргийн багийн ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтад үнэлгээ хийх санал гаргах, цэргийн багт ажиллагааны өмнөх бэлтгэлийн үеэр цэргийн ур чадварын үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. НҮБ-ын төв штаб дэлхий дахиныг хамарсан цар тахлын улмаас бүх үйл ажиллагаа одоо ч онлайн аар явуулж байгаа ба орчин үеийн технологийн хөгжлийг ашиглан онлайн аар тухайн улсаа ажиллагааны өмнөх бэлтгэлийг хийж буй батальонд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулахад оролцлоо. Бэлтгэл ажлыг хангахад маш их хугацаа, зохион байгуулалтын ажлууд орсон. Одоо энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй мотобуудлагын батальонуудын үүрэг гүйцэтгэлтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулаад системд оруулж байна. Бүх ажиллагаанууд болон цэрэг илгээгч улс орнууд нэгэн ижил үзүүлэлт, стандартаар батальонуудынхаа үүрэг гүйцэтгэх чадварыг үнэлэх боломж бүрдэнэ. Он гаргаад ажиллагаануудад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн ажиглагч офицерууд, штабын офицеруудын үүрэг гүйцэтгэлийг үнэлэх стандарт үзүүлэлтүүдийг боловсруулах ажилд оролцох юм.

Цэргийн асуудал эрхэлсэн алба нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа дахь цэргийн хүчний бүх асуудлууд, тухайлбал, цэргийн хүчний төлөвлөлт, цэргийн хүчний номлол, бодлого тодорхойлох, цэргийн хүчний бүтэц, зохион байгуулалт, цэргийн хүчнийг бүрдүүлэх, үүрэг гүйцэтгэлт, өдөр тутмын үйл ажиллагаа, аюулгүй байдлын асуудлууд, цэргийн сургалт бэлтгэл, үүрэг гүйцэтгэлтэд дүн шинжилгээ хийх гээд цэргийн хүчинтэй холбоотой бүхий л асуудлыг хариуцаж ажилладаг. Өнөөдрийн байдлаар НҮБ-ын штабт Энхийн ажиллагааны газар, Ажиллагааны дэмжлэгийн газар зэрэгт нийт 110-аад цэргийн албан тушаалд 70 гаруй орны нийт 110 орчим офицер үүрэг гүйцэтгэж байна. Энэ албан тушаалуудад хошууч, дэд хурандаа, цөөн тооны хурандаа нар алба хаадаг. НҮБ тухайн офицеруудыг түр хугацаанд (2 жил, цөөн тохиолдолд 1 удаа 1 жилээр сунгана) ажиллуулдаг тул “secondment” гэж нэрлэдэг.

Өндөр хариуцлагатай, чамгүй мэдлэг боловсрол, туршлага шаардсан алба юм байна. Шалгаруулалтын босго ч өндөр байх.

-Эдгээр албан тушаалыг цэрэг илгээгч улс орнуудын дунд нээлттэй зарладаг ба нэр дэвшигчдийн материалыг тухайн улс орны Байнгын төлөөлөгчийн газраар уламжлуулан хүлээн авч НҮБ-аас сонгон шалгаруулдаг. Манай Зэвсэгт хүчний офицерууд энэхүү сонгон шалгаруулалтад 2014 оноос хойш оролцож байгаа. Хурандаа Д.Болор НҮБ-ын төв штабт ажилласан анхны монгол офицер. Энэ жилийн Цэргийн ажиллагааны хэлтсийн сонгон шалгаруулалт явуулахад саналаараа оролцож, ирсэн баримт бичгийг судлан бичгийн шалгалтын материалыг засалцсан. Хоёрхон албан тушаалын сонгон шалгаруулалтад 30 гаруй орны 300 гаруй хүний материал ирж байна лээ. Тэгэхээр ямар их өрсөлдөөнтэй байдаг нь ойлгомжтой болов уу.

(Үргэлжлэл нь XI нүүрт)

Д.Мягмаржав: БАГШ ХЭМЭЭХ ЭРХЭМ НЭГЭН “ЧИМЭГ”-ТЭЙДЭЭ БАЯРЛАЖ, БАХАРХАЖ ЯВДАГ

(Түрүүч нь Х нүүрт)

Миний хувьд энэхүү сонгон шалгаруулалтад өмнө нь нийт 3 удаа материалаа өгснөөс 2019 онд тэнцэн үүрэг гүйцэтгэж байна. Мэдээж зөвхөн англи хэлний өндөр мэдлэг бус энхийг сахиулах ажиллагааны талаарх мэдлэг, туршлага, штабын офицерын ур чадвар гээд олон асуудлыг харгалзан үздэг юм байна. Хэрхэн бэлтгэж тэнцсэн тухайд гэвэл, чамгүй материалуудыг уншиж судалсан. Ялангуяа НҮБ-ын зүгээс баримталж буй бодлого, чиг хандлагыг судалсан. Хурандаа Т.Галбадрах, хурандаа Д.Болор гээд цөөнгүй хүнээс зөвлөгөө авч түүнийгээ сайтар баримталж ажилласан даа. Бичгийн шалгалтад тэнцэн ярилцлагад оролцож болсныг Монгол Улсаас НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчийн газрын Цэргийн зөвлөх, бригадын генерал Б.Даваадорж мэдэгдэх тэр үед Батлан хамгаалахын сайд асан Н.Энхболдыг дагалдан Сингапур Улсад зохион байгуулагдсан бүс нутгийн уулзалтад оролцож байсан юм. Сайд сонсоод “Сайн бэлтгээд тэнцчих юм сан” гэж өөрөө шалгалт өгөх гэж байгаа юм шиг хэлэхэд нь маш их урамшсан. НҮБ-д учир байдлаа танилцуулаад Монголд ирсэн өдрийнхөө маргааш орой нь ярилцлагадаа орсон юм. Тэнцсэн эсэх тухай хариуг 2 сар гаруй хүлээсэн дээ. Ажилдаа томилогдоод явах болсноо БХЯ, ЗХЖШ-ын удирдлагуудад илтгэхэд улс орныхоо нэр хүндийг өндөрт өргөж ажиллахыг, их зүйлийг сурч, дараа дараагийн хүмүүсийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, өмнө татсан шанг улам тод болгох үүрэг өгч амжилт хүсэхэд нь ихээхэн урам, эрч хүч авсан шүү.

Багагүй хугацаанд гадаадын улс орнуудад ажиллаж, үүрэг гүйцэтгэсэн таны хувьд эх орон гэж юу вэ? Эх орны үнэ цэнийг юу гэж тодорхойлох вэ?

“Дэлхийн бодлогыг тодорхойлж буй хоёр том гүрний дунд орших Монгол хэмээх нутгийг олж тэр дундаа хангай, говь, тал нутаг хосолсон сайхан нутагт хүн болж төрснөөрөө үргэлжийн мөнхөд бахархаж, багдаж явдаг. Монгол Улс минь нэгэн цагт ертөнцийг доргиож ч явсан, мөхөж үрэгдэх шахаж ч явсан. Монгол хэмээх улсаа тусгаар байлгах гэж олон олон аавын хөвгүүд, охид алтан амиа өргөж, цусаа урсгаж, ясаа хэмхлүүлэн эх орноо өндийлгөж, босгосон ийм л улс. Бусад улсаас бид олон зууны түүхээсээ гадна ийн унаж, босож явсан энэ түүхээрээ ялгарах учиртай. Удахгүй бид улс орноо дэлхийн бодлого тодорхойлдог том гүрэн болно гэдэгт огт эргэлздэггүй. Эх орон гэдэг бол юугаар ч, яаж ч үнэлж, цэгнэж болохгүй хүний хамгийн эрхэм нандин зүйл. Би энэ их үйл хэрэгт өчүүхэн ч гэсэн үйл, үйлдлээ зориулж яваа гэж байнга бодож, хичээж явдаг. Ялангуяа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж явахдаа, гадаадын оронд сургалт, дамжаанд хамрагдаж явахдаа илүү чармайдаг. Хийж



байгаа үйлдэл, хэлж байгаа үг минь хүртэл Мягмаржав гэж хувь хүн гэдгээсээ илүү Монголын офицер гэж хамгийн түрүүнд хүрдэг. Мөн Мягмаржав гэдэг нэр бараг дурдагдахгүй аавын минь нэр л үргэлж дуудагдаж байдаг. Би заримдаа ааваараа тоглоод энэ хуралд, энэ ажиллагаанд Мягмаржав гэж хүн биш Дорж гэдэг хүн л оролцоод яваад байна шүү гэдэг юм. Мэдээж аав минь, ах, дүү нар, эгч минь баяртай л явдаг байр.

Эх орноо санахаараа та ямар үйлдэл хийдэг вэ?

“Сайхан дуу сонсдог. “Хурд” хамтлагийн “Санаж байна”, “Монголтойгоо адилхан”, “Харанга”-ын “Зөвхөн Монголдоо”-г сонсож хэсэг гэгээлэнэ шүү дээ. Мөн Н.Жанцанноровын “Цагаан суварга”, “Тогосын цагаан овоо”-г сонсох дуртай. Айраг ууж шалхигүй ч гэлээ зун болохоор сайхан айраг залгилах юм сан гэж, өвөл цас хаялсан намуун оройг, нэвсийтэл цас буучихсан дулаахан өглөгөө, тачигнатал шуурсан өдрийг хүртэл санадаг.

Ажил, амьдралдаа баримталдаг гол зарчим ...

“Аливаа ажлыг хийхдээ чин сэтгэлээсээ хийхийг л зорьдог. Юуг ч, ямар ч ажлыг сэтгэлээ шингээн хийж байвал тэр бүхэн бусдад хэчнээн сайхан харагдаж, эргээд өөрөө түүнийхээ үр шимийг харамгүй хүртдэг юм болов уу. Амьдралыг чи алтаар үнэлбэл Амьдрал чамайг алтаар мялаана Эс тоож сохор зоос шиг хандвал Эргээд амьдрал чамайг элсийн ширхэг шиг үлээчихнэ ээ гэсэн яруу найрагч Р.Чойномын нэгэн шүлгийн мөртүүдийг байнга бодож явдаг.

Таны хувьд найз нөхөд гэж хэн бэ? Найз нөхөд олонтой байхын сайхныг хэзээ хамгийн ихээр мэдэрсэн бэ?

“Маш олон найз нөхөдтэй баян хүн дээ, би. Хаана ч очсон найзууд минь туслан дэмжиж, тэднийхээ итгэл сэтгэлийг хүлээж

явдаг. Би БХИС-ийн инженерийн мэргэжлээр төгссөн 3 дахь төгсөлтийн офицеруудын нэг. Одоо манай курсийн найзуудаас маань цөөнгүй хүн БХЯ, ЗХЖШ-т мэргэжилтэн, ангийн захирагч, штабын дарга зэрэг албан тушаалд томилогдон албаа нэр төртэй хашиж байна. ОБЕГ, Цагдаагийн алба, хувийн хэвшилд ч нэр төртэй албаа хааж явна. Найзуудаараа үргэлж бахархаж, тэдэндээ үргэлж баярлаж явдаг. Найз нөхдөөрөө бахархах, тус дэмийг нь авах, зовлон, жаргалаа хуваалцах үе олон байлгүй яах вэ. Онцолж хэлбэл бусад нь гомдчих байх.

Амьдралдаа хамгийн их талархаж, баярлаж явдаг хүн чинь хэн бэ? Яагаад?

“Хүн болж энэ орчлонд мэндэлснээс өдийг хүртэл олон хүний хүч, дэмжлэгээр өдий зэрэгтэй яваа. Эрдэмтэн багш, хамт олон, дарга, захирагч нар, найз нөхөд, хамаатан садан, ах, эгч, дүү нар, хайртай хань, гурван сайхан үрсийнхээ тус дэмээр л хүний дайтай явна даа. Намайг өдий зэрэгт хүргэсэн та бүхэндээ бүгдэд нь маш их баярлалаа гэж хэлье. Мэдээж хүмүүн заяаг олж хүний үр болсон болохоор бие сэтгэл юугаа хуваан байж төрүүлсэн ээж, аавдаа хайртай, тэдэндээ үргэлж баярлаж, талархаж явдаг. Хүргэн ах минь миний хамгийн эрхэм хүндэт хүн байлаа. Хүн байхын учрыг, хүнийг хүндэтгэж, хайрлахын эрдмийг энэ хүнээс л сурсан. Хүүгээ амжилттай сайн явааг тэнгэрийн орноос хараад машинд ихээр баярлаж суугаа байх даа л гэж боддог. Бас эгчдээ үргэлжийн мөнхөд талархаж явах ёстой хүн. Намайг өөрийн хүүхэд шигээ хайрлаж юугаар ч дутаахгүй өсгөн хоолонд минь хүргэсэн хүн. Амьдралын хатуу хөтүүг туулж яваа, олондоо нэртэй, гайхалтай мундаг эмч бий дээ, миний эгч. Энэ дашрамд эгч А.Оюун, дүү М.Бямбадулам хоёртоо чин сэтгэлийн мэнд хүргэе. Бид тав нь та хоёртоо хайртай шүү, хамгийн сайн сайхныг хүсье.

Алдаанаасаа суралцадаг уу эсвэл бусдын алдаанаас суралцадаг уу?

“Аль алианаас нь л суралцдаг. Гэхдээ бусдын гэхээсээ илүү өөрийнхөө алдааг олж түүнээсээ сургаж авахыг эрхэмлэдэг. Мэдээж хүн бүрийн харах өнцөг ондоо тул миний том алдаа өөр хүнд нэг их ач холбогдол өгөөд байхааргүй ч байж магадгүй. Тэгэхээр алдахаас айхгүй байхыг л хичээдэг дээ. Мөн өө хайгаад л байвал, эсвэл яах бол гээд эргэлзээд байвал хаанаас ч, юунаас ч алдаа гаргаад л ирэх байх. Өөрийнхөөрөө л зүтгэж, алдаж онож амьдарна даа.

Тэнгэрт тултал гэдэг шиг магтуулж байсан тохиолдол ...

“Магтуулсан нь цөөнгүй. Гэхдээ ихэнхдээ л “сэгсийтэл” загнуулсан байх. Энэ асуултыг ингээд бөөрөнхийлөөд хөгжилтэйгөөр хариулчих уу?

Өөрийгөө магтчихсан болно гэж бодоод л хариулахгүй байна аа даа. Тэгвэл амжилт гэж чухам юуг хэлэх вэ?

“Амжилт гэж хүний хүрэхийг мөрөөдөж түүндээ цаг хугацаа, бие, сэтгэл бүхнээ зориулсан зорилго, хүрэхийг хүссэн тэр оргил нь юм. Нэг зорилгын дараа дараагийнх нь гарна, түүнийгээ дагаад амжилтууд хөвөрнө. Зорилго бол төгсгөлгүй хүсэл мөрөөдөл, түүнд хүрэх тэмүүлэл, амжилт бол зорилго, мөрөөдөлдөө хүрснийг илтгэх нэгэн хэмжүүр.

Гэр бүлээ танилцуулахгүй юу?

“Миний ханийг Ш.Саранцэцэг гэдэг. Санхүү, эдийн засгийн мэргэжилтэй, хувийн аж ахуйн нэгжид нягтлан бодогч хийж байсан. Бид оюутан байхдаа танилцаад 2002 онд гэр бүл болсон, гурван хүүхэдтэй. Цэргийн хүний гэргий нарын л адил гэр орныхоо хүнд ачааг үүрч яваа жирийн нэгэн бусгүй. Надаас л болоод энэ хүний ажилдаа амжилт гаргах боломж нь хязгаарлагдсан гэж бодохоор эвгүй л байдаг юм. Ажил, албаны минь жаргал, зовлон, хүсэл тэмүүллийг минь маш сайн ойлгодог, мэддэг болохоор гэр бүл маань халуун дулаан хайраар дүүрэн байдаг.

Таны хүү цэргийн мэргэжил сонговол та яах вэ? Яагаад ...

“Хүсэл, мөрөөдлийг нь дэмжинэ. Ямар ч мэргэжил сонгосон хамгийн гол нь хүүхдүүдийн маань чин хүсэл байх хэрэгтэй. Тэгвэл түүндээ сэтгэл, зүрхээ зориулан түүнээсээ сэтгэлийн таашаал авч аз жаргалтай амьдрах байх. Хүсээгүй ламд дарж байгаад сахил хүртээх ч амжилтанд хүргэхгүй л болов уу.

Ойрын зорилгыг тань хуваалцаад ярилцлагаа өндөрлөх тийшээ хандъя ...

“Мэдээж онгодсон ажлаа сайн хийх нь яг одоогоор ойрын минь зорилго. Хувийн амьдрал, ар гэр, үр хүүхдийнхээ төлөө, алба ажлынхаа талаар гээд л олон зорилготой. Түүнийгээ биелүүлэхийн тулд хичээн чармайж л явна.

Ярилцлагын төгсгөлд багш хүний үүднээс уншигчдад маань зөвлөгөө өгөхгүй юу?

“Холыг харж хязгааргүй мөрөөдөж, түүнийхээ төлөө тууштай байхыг л зөвлөмөөр байна. Мөрөөдөлдөө хүрэхийн тулд өөрөөсөө шалтгаалж болох бүхнийг хийх хэрэгтэй. Шантарч болохгүй. “Нэг хаалга хаагдахад зуу зуун өөр хаалга нээгддэг” гэж нэг үг бий. Тиймээс унасан ч босоод дахиад л зүтгэх хэрэгтэй. Сурах, мэдэх чин хүсэлдээ хөтлөгдсөн хүмүүс илүү их амжилтад хүрдэг.

Цаг гарган ярилцсанд баярлалаа. Танд амжилт хүсье.

Дэд хурандаа Х.ГАНЗУЛ

ЦАХИМ ДЭЛХИЙ

Сэтгүүлч Л.Мөнхбаясгалангийн эл бичвэрүүд цахим ертөнцөд маш олон хүний талархлыг хүлээсэн юм.

Munkhbayasgalan Bayasgalan Oct 20

МАРГААШ ХҮҮГЭЭ ЭХ ОРОНД НЬ ӨГНӨ

Маргааш Улаанбаатар хотод цэрэг татлага явагдана. Бусад ээжүүдийн адилаар би хүүдээ сүү амсуулж, эр цэргийн албанд үдэж мордуулна. Энэ цаг мөчийг би 18 жил хүлээжээ. Тэр өдөр маргааш тохиох нь. Энэ хорвоод бүсгүй хүн болж төрснийхөө үргийг биелүүлж би хүү төрүүлсэн. Тэгээд хүүгээ эрүүл саруул өсгөж эх орноосоо, эр цэргийн албанаас зугтдаггүй сэтгэлтэй иргэн болгон хүмүүжүүлж эх хүний үүргээ дахин нэгэнтээ биелүүллээ. Харин маргааш эх оронд нь хүлээлгэн өгнө. Ямархуу эр хүн болгож эх орондоо хэрхэн зүтгүүлэхээ одоо Монгол Улсын Зэвсэгт хүчин мэдтүгэй ... Хүүгээ 5 дугаар ангид сурч байхад нь 3 сар Япон улсад сургуульд явуулсан юм. Тэгэхэд би жаалхан хүүдээ “ээжийгээ санавал, аавыгаа санавал энэ Төрийн далбаагаа өвөртлөх унтаарай. Ээж, аав хоёрыг чинь эх орон орлодог юм. Эх орныг чинь энэ Төрийн далбаа төлөөлдөг юм” гэж Монгол Улсынхаа алтан соёмбот далбааг чөмөндан нь хийж өгч билээ. Тэр цагаас хойш он цаг улирсаар хүү эрийн цээнд хүрч эх орны дуудлага, эр цэргийн зарлан өвөртлөв ... Тиймээ маргааш хүүгээ эх оронд нь хүлээлгэн өгнө. Ямар хүү төрүүлснээ ээж нь харлаа, одоо ямар эр болгон төлөвшүүлэхээ эх орон нь мэдэг ээ ... Ээж, аавын жаахан хүү байсан бол ингээд эх орны эр цэрэг боллоо, миний хүү. Төрийн минь сүлд өршөө ...



12K 582 Comments • 366 Shares

Like Comment Share

Munkhbayasgalan Bayasgalan 6d

Эх орноо батлан хамгаалахаар цэргийн албанд мөрдсөн хайрт хүү минь амархан сайн байна уу. Алс холын Улаанбаатар хотоос цас бударсан бүрхэг энэ өдөр хүүгээ санагалзан ээж нь энэхүү захиаг бичиж сууна. Өнөөдөр 11 дүгээр сарын 16. Дэлхийн дайдыг морин туурайгаар хэмжиж байлдан дагуулсан мянганы хүнээр тодорсон суут Богд Чингис хааны мэндэлсэн

... ДУГААР АНГИД АЛБА ХААЖ БУЙ ХҮҮДЭЭ БИЧСЭН ЗАХИА

өдөр. Дэлхийг цочроосон цар тахлаас болж улс даяар хатуу хөл хорио тогтоогоод яг 5 хонож байна. Ээж нь өчигдөр фэйсбүүкээс шалан дээр мөр мөрөө дэрлэн суугаад амарч байгаа цэргүүдийн зургийг олж үзлээ. Цар тахлаас болж бүх нийтийн бэлэн байдал ажиллаж байгаа цагдаа, цэрэг, онцгойгийн албан хаагчид бидний төлөө нойр, хоолгүй бэлэн байж, суух ч сандалгүй шалан дээр шавааралдан байгааг харсан минь тэр. Хүмүүс тэдний зургийг хараад их л өрөвдөж байгаа бололтой. Харин ээж нь тэднийг хараад хүүгээрээ бахархах сэтгэл улам нэмэгдэв. Эх орондоо тангараг өргөсөн эрсийн хийх ажил энэ шүү дээ. Миний хүү ч гэсэн эх орон тушаахад тэдэн шиг бэлэн байгаа гэж бодохоор сэтгэл, зүрх баяраар бялхаж ирэв. Миний хүү шиг хэдэн зуун мянган эр цэрэг эх орны команд хүлээн хүн ардынхаа сайн сайхны төлөө бүх нийтийн бэлэн байдалд байгаа гэж бодохоор эх бүрийн өмнөөс хайр хүрч байна. Ээж нь хүүгээ өдөр, шөнөгүй санавч эх орны эр цэрэг болсон гэж бодохоор бахархаж бас омогших юм аа. Миний хүү одоо өглөө бүр “сэрээд” командар босож Төрийн далбаагаа мандуулж, орой бүр Төрийн дууллаар унтаж байгаа даа ... Хүүгээ цэрэгт мөрдсоны маргааш ээж нь Халхын голоос эхлээд эх орныхоо зүүн хилийн дөрвөн отрядаар явж сурвалжилга хийсэн. Хүү минь Зэвсэгт хүчинд бүтээн байгуулалтын цэрэгт явсан бол ердөө маргааш нь л ээж нь улсын хилээ батлан хамгаалж буй хилийн цэрэгт “явсан” даа. Эх орны торгон хил гэдэг юутай сэтгэл хөдөлгөм бахархал, омогшил билээ. Энэ бүхнийг бодож явахдаа ээж нь хүүгээ ямар их санасан гэж бодно. Ээж нь домогт Халхын голын цэргийн анги дээр чамтай чацуу шинэ цэргүүдтэй уулзсан. Тэд захны давуугаа хадах гэж сандран, өглөө босох гэж өөртэйгөө хэрхэн тэмцэж байгаагаа ярьж байна билээ. Гэхдээ тэд амархан жигдэрч байгаа харагдсан шүү. Ээж нь хүүгээ санахын цагтаа тэднийг бүгдийг нь тэвэрч аваад үнсэмээр, захны давууг нь хадаж өгмөөр санагдсан. Хилийн цэргийн ангиудаар явж сурвалжилга хийхдээ Зэвсэгт хүчинд алба хаахаар явсан хайрт хүүгээ ямар их санасан гэж бодно оо. Гэхдээ эх болгоны хүү адилхан юм байна, ээж бүхэн эр цэрэгт мөрдсөн хүүгээ санаж хамтдаа өглөө босож, хамтдаа жагсаалд хөл тавьж, хамтдаа тангараг өргөх юм байна

гэдгийг ээж нь ойлгосон. Эх орны эр цэрэгтэй хамт эх болгон алба хашдаг юм байна шүү, үр минь.

“Улсын сүр цэрэгтээ, цэргийн сүр жагсаалдаа” гэсэн үг бий. Миний хүү чинь цэрэгт татагдаж, төрж өссөн Улаанбаатар хотоосоо хэдэн зуун километрийн алсад одсон тэр өдрөөс хойш одоо аль хэдийнээ жавхайсан цэрэг болсон байлгүй. Миний хүүд цэргийн хувцас сайхан зохисон байх даа. Бугаа мөрлөж, жагсаалдаа жигдэрч, тэвхийтэл ёслоод Төрийн далбаагаа харан бахархаж зогсоо болов уу. Газар газраас татагдан ирсэн олон аавын хүүтэй мөр зэрэгцэн аль хэдийнээ хатуужиж золбоо хийморьтой эр хүн болсон байх. Ээж нь хүүгээ ингэж л төсөөлж, ингэж л бодож таарсан, уулзсан болгондоо хүүгээрээ гайхуулсаар сууна. Харин гурван жилийн цэргийн алба хаасан аав, өвөө хоёр нь байсхийгээд л өөрсдийнхөө цэргийн алба хааж байсан сонинсоос ярих дуртай болсон. Бодвол чамайг санаж байгаа бололтой. Хүү минь чи бид хоёр “Чингис хаан” киног үзэх дуртай, “Монголын нууц товчоо”-г хэдэн ч удаа уншсан билээ. Монгол эрчүүд бол маш богино хугацаанд цэргийн зохион байгуулалтад орж чаддаг, утаан дунд ч, ус цасан дунд ч, унтах ноёрондоо ч хуяг, дуулгатайгаа явж эх орон, ард түмэн, ижий бүрийнхээ төлөө дэлхийг эрхшээж чаддаг түүхийг миний хүү мэднэ дээ. Монгол эрчүүд тэр дундаа монгол эр цэргийн сүр хүч бол суу алдарт түүх билээ, сүр жавхланын домог билээ ... Хүү минь, эх хүн хүүгээ бүхнээс харамлаж бас хамгаалж, өмгөөлдөг. Харин эх орноосоо л хүүгээ харамладаггүй билээ. Ижий бүрийн сэтгэл дотор эх орон бүхлээрээ багтдаг болохоор эх орондоо л хүүгээ эргэж буцалтгүй өгдөг жамтай. Энэ жил цар тахлын хатуу хөл хорионоос болоод “Тангаргийн баяр”-т нь очиж чадахгүй нь бололтой. Гэхдээ энэ нь эр цэргийн тангарагт ямар нөлөө байх билээ. Миний хүү монгол цэргийн сүр хүч оршсон Байлдааны тугандаа тангараг өргөж энэхүү цаг үед өдөр, шөнөгүй нүд цавчилгүй зогсох нь унэн юм чинь. Энэ дэлхий дээр итгэл төгс юу байна гэвэл ганцхан энэ л байна. Хүү минь ижий нь чамдаа хайртай юм шүү. Ээж нь чамаар бахархаж бас санаж байгаа учраас алс холын Улаанбаатараас энэхүү захиаг бичлээ. Ээжийн хайртай хүү одоо эх орны эр цэрэг боллоо. Үеийн үед, ургийн урагт ийм л эрчүүдийн нуруун дээр эх орон, ард түмэн минь бүтэн оршиж ирлээ. Ижий бүрийн сэтгэл амгалан байг. Эр цэргийн сүр жавхлан жанжин туг шигээ босоо байг ээ.

Жич: Цар тахлын хорио тавигдаж цагийн байдал амгалан болохоор хүүдээ давхиад очно оо. Тэгээд хүүгийнхээ цэргийн хувцастай зургийг авах юм шүү. Миний хүүд цэрэг хувцас сайхан зохисон байх даа ... Түр баяртай.

... Дугаар ангийн байлдагч И.МАРГАД-ЭРДЭНИЙН ээж Л.МӨНХБАЯСГАЛАН алс тэртээ Улаанбаатараас ёслол.

2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

СОНИРХУУЛБЯ

ТУЛАЛДААНД ЗӨВХӨН ШОНХРУУД НИСДЭГ

XX зууны эхэнд дэлхий дахинд дайны хар шуурга дээдсэн тэрхүү цаг үеийг Европ тивийн тэнгэрт салхи мэт эрчлэн дүүлэх нисэх онгоцгүйгээр төсөөлөхийн аргагүй. Тэр тусмаа Хүн төрөлхтний түүхэнд анхны байлдааны нисгэгчдийг бэлтгэн, Дэлхийн нэгдүгээр дайнд оролцуулж байсан нь амь өрсөж, аюул, эрсдэлийг дагуулсан хэдий ч өмнө нь хэзээ ч байгаагүй баатарлаг амжилтуудыг бий болгожээ. Тэдгээр анхны зоригт нисгэгчдийн талаарх баримтуудыг уншигч танд хүргэе.

"УЛААН БАРОН"

Нисгэгч Манфред фон Ричтофен бол Герман улсын урдаа барьдаг шилдэг нисгэгчдийн нэг байв. Дайсны хүчийг олноор нь устгадаг тун чадварлаг нисгэгч байсан тул түүнийг британчууд "Улаан Барон", францчууд "Улаан чөтгөр" (Францаар "Diable Rouge") хэмээн нэрлэдэг байв. Манфред 1892 онд Пруссийн язгууртан гэр бүлд төрсөн бөгөөд Дэлхийн нэгдүгээр дайнд нисгэгчээр үүрэг гүйцэтгэхээс өмнө морин цэргийн салааны залуу офицер байжээ. Улмаар 1916 оны 9 дүгээр сард анхны нислэгээ үйлдэн, агаарын тулалдаанд оролцсон байна. Түүнээс хойш хоёр жилийн дараа буюу 1918 оны 4 дүгээр сар гэхэд нийт 80 онгоцыг сөнөөж чадсан нь тухайн үеийн нисгэгчдээс хол илүү үзүүлэлт болж түүхэнд тэмдэглэгджээ. Энэ нь түүнд алдар цууг авчирч, өөрийнх нь нисэх онгоц хүртэл "Нисдэг цирк" хочийг авсан гэдэг.


Байлдааны гайхамшигтай, ур чадвартай хэмээн үнэлэгдсэн Манфред хамгийн нарийн тактикуудыг ашигладаг байв. Тухайлбал, дайсны нисгэгчийн анхаарлыг ямар нэгэн байдлаар сарниулан, мэдэгдэхгүйгээр эгц дээрээс нь пулемётор галладаг байжээ. Манфред сөнөөсөн онгоцнуудаа мөнгөн аягаар төлөөлүүлэн дурсгал болгон цуглуулдаг байсан гэлцдэг.

Харамсалтай нь тэрээр Дэлхийн нэгдүгээр дайн дуусахаас зургаахан өдрийн өмнө буюу 1918 оны 4 дүгээр сард Францын хойд хэсэгт "Сомме голын байлдаан" гэж нэрлэгддэг тулалдаанд амь үрэгджээ. Түүний цогцос олодоогүй учир дайн дууссаны дараа оршуулгын ёслолыг нь хүндэтгэлтэйгээр зохион байгуулсан байна. Тэрхүү ёслолд оролцсон англи цэргүүд "Бидний хүчирхэг, зоригт дайсан" гэсэн бичээс бүхий цэцэгсийг эгнүүлэн тавьж байсан талаар сонирхолтой түүх бий.

АЛЬБЕРТ БАЛЛ

Британийн нисгэгч Альберт Балл Дэлхийн нэгдүгээр дайнд 44 онгоц сөнөөсөн нь бусад нисгэгчдээ бодоход өндөр үзүүлэлт биш ч гэсэн тайван дөлгөөн, тун даруухан зантай байсан нь олны анхаарлыг татдаг байв. Тэрээр өөрийн амьдардаг жижигхэн байшингийн гадаах талбайг цэцэрлэгжүүлэхэд өдрийнхөө ихэнх хугацааг зарцуулдаг байсан гэдэг.

Альберт хэдий дуу цөөн, даруухан зантай нэгэн байсан ч агаарын тулалдаанд орохдоо хамгийн эрсдэлтэй, амь өрсөн үйлдлүүдийг хийж, дайснаа бут ниргэдэг байсан нь түүнийг олны танил болгосон юм. Тэрээр олон удаа Германы цэргийн баазуудыг дээрээс нь бөмбөгдөн устгаж байжээ. Альберт ихэнхдээ Францад үйлдвэрлэсэн "Nieuport" загварын нисэх онгоцыг жолооддог байсан бөгөөд дайны нисгэгчдийн доороос нь галлаж сөнөөдөг тактиктэй байсан гэдэг. Гэвч тэрээр тухайн үед дөнгөж 20 настай залуу нисгэгч байсан учир олон удаагийн тулалдаанаас үүдэлтэй сэтгэл санааны гүн хямралд өртжээ. Альберт 1917 оны 5 дугаар сард "Улаан Барон"(Манфред фон Ричтофен)-ы гарт амиа алдахад түүний сэтгэл санааны хямрал нөлөөлсөн гэж түүхчид үздэг байна.



ЭДДИ РИКЭНБЭЙКЭР



Америкийн шилдэг нисгэгч нарын нэгээр нэрлэгддэг Эдди Рикэнбэйкер нь нисгэгч болохоосоо өмнө АНУ-ын Индианаполис хотод зохиогддог байсан "Daytona 500" нэртэй автомашины уралдааны анхны аварга болж тухайн үедээ хамгийн их зайг, хамгийн богино хугацаанд автомашинаар туулсан дэлхийн дээд амжилтыг эзэмшиж байв. Тэрээр Америкийн генерал Жон Ж.Першингийн жолоочоор ажиллаж байгаад 1918 оны эхээр нисэх онгоцны жолооч болохдоо 27 настай байжээ. Эдди өөрийгөө шилдэг ур чадвартай нисгэгч гэдгээ олон удаа батлан харуулж байв. Тухайлбал, 1918 оны 9 дүгээр сард агаарын тулалдаанд орж байхдаа Германы долоон онгоцоор эргэн тойрондоо бүслүүлсэн эрсдэлтэй байдлаас мултарч чаджээ. Энэхүү гайхамшигт ур чадварыг нь үнэлж Америкийн Засгийн газар түүнд Алдар хүндийн медаль (Medal of Honor) олгосон удаатай.

Эдди Рикэнбэйкер агаарын тулалдаанд нийт 26 удаа ялалт байгуулж чадсаны 18 нь ердөө 48 хоногийн хугацаанд болж өнгөрсөн байдаг. Тэрээр онгоцны хоёр ч ослоос амьд үлдсэн бөгөөд нэг удаа түүний онгоц Номхон далайд осолдож 22 хоног ганцаараа хөсөр хаягдсан ч эсэн мөнд аврагдаж чаджээ.

"ТАМЫН ШИВЭГЧИН"




Канадын нисгэгчид Дэлхийн нэгдүгээр дайнд гайхалтай амжилтыг шинэчлэн тогтоож байсан боловч 72 удаа агаарын тулалдаанд ялалт байгуулсан Уильям Бишопийн гайхалтай амжилтыг эвдэж чаддаггүй байв. Уильям дайны эхний жилүүдэд морьт цэргийн салаанд үүрэг гүйцэтгэж байсан боловч удалгүй Канад улсын Нисэх хүчинд элсэн оржээ. Тэрээр 1917 оны 3 дугаар сард анхны тулаандаа орохдоо Германы таван онгоцыг сөнөөсөн гэдэг. Түүний сур хүчинд автсан Германы нисгэгчид Бишопийг "Тамын шивэгчин" хэмээн нэрлэдэг байжээ.

Бишоп уран чадварлаг нисгэгч байгаагүй ч сайн мэргэн буудагч байсан юм. Ур чадвараа хөгжүүлэхийн тулд тэрээр нисэх онгоцны бүхээгээсээ цагаан тугалган лааз доош унагаж, бай болгон бууддаг байсан гэдэг. Тэрээр тулалдаанд ганцаараа оролцохыг эрхэмлэдэг байсан нь дээд удирдлагын дургүйцлийг хүргэсэн ч тэр хэрээр алдар хүндийг олжээ. Хэдий хууль бус аюултай алхмыг туршдаг байсан ч нэг удаа Германы гурван онгоцыг ганцаарчилсан довтолгоогоор устгаж чадсан байна. Гэвч энэ үйл явдлын дараа буюу 1918 оны 6 дугаар сард дээд удирдлагаас түүний дураараа байдлыг таслан зогсоох үүднээс үүрэгт ажлаас нь чөлөөлжээ.

Бэлтгэсэн дэд ахлагч Т.ИДЭР

АЗ ЖАРГАЛ



ГЭРЭЛ ЗУРГИЙГ Г.ЭРДЭНЭТУЯА


Энэхүү гэрэл зургийг уншигч та андахгүй мэдэх байх. Цахим ертөнцөд олон хандалт авч, янз бүрийн тайлбартайгаар сайт, нүүр номын хуудсуудад байршсан. Зөвхөн дотооддоо ч бус гаднын улсын сайтуудад ч түгээгдсэн нь цөөнгүй. Харин хэн, хэзээ авсан, ямар үүх түүхтэй болохыг нь тэр бүр мэдэхгүй болов уу. Гэрэл ур зургийг Монголын цөөхөн эмэгтэй гэрэл зурагчдын нэг, УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн гэрэл зурагчин Г.Эрдэнэтуяа авчээ.

Түүнтэй холбогдож уг бүтээлийнх нь талаар тодруулсан юм.

Тэрээр "2012 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Сүхбаатарын талбайн ойролцоо ажлаар явж байгаад талбай дээр энэ хоёрыг харсан юм. "Найзууд дугуй унаж бага насаа дурсаж байна даа" гэж бодоод энэхүү агшныг дурандаа буулгасан. Тухайн үед би "Өнөөдөр" сонинд гэрэл зургийн албаны дарга, гэрэл зурагчнаар ажиллаж байсан. Зургаа "Аз жаргал" гэж нэрлэн сониндоо нийтэлж, 2013 оны 11 дүгээр сарын

1-ний өдөр нээсэн "Ертөнцийн өнгө" гэрэл зургийн хамтарсан үзэсгэлэндээ дэлгэсэн.

Үзэсгэлэнд гарахаас өмнө цахим ертөнцөөр тарж хэзээний олны танил болсон байсан шүү. Анхандаа найзууд гэж бодсон, хожим нь ах, дүү хоёр болохыг нь мэдсэн" гэж зургийнхаа түүхийг



хуваалцсан юм. Тус бүтээл "Аз жаргалын эрэлд" гэрэл зургийн уралдааны шагналтай бөгөөд Япон улсад зохион байгуулагдсан гэрэл зургийн үзэсгэлэнгээс "Олны таашаал хүртсэн гэрэл зураг"-аар шалгарчээ. Гэрэл зураг дээрх лам нь Гандантэгчинлэн хийдийн "Жүд" дацангийн дорж ловон, аграмба А.Баасаням бөгөөд тухайн үед Энэтхэг улсад сурч байгаад түр ирсэн байжээ. Харин цэргийн алба хаагч нь түүний төрсөн дүү аж. Хэрвээ өөрсдийнхөө зургийг хараад холбогдвол гэрэл зургийг нь угаалгаж бэлэглэнэ гэж зурагчин маань дамжуулсныг уламжилъя.

Х.ЗУЛ